



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2025 оны 04 сарын 25

WEB APPLICATION FIREWALL

Таны вебсайт болон аппликейшныг гадны халдлагаас бүрэн хамгаалах **Web Application Firewall** үйлчилгээ эхний сар **100%** үнэгүй.


УРАМШУУЛЛЫН КОД: WAF100



Хүссэн вебсайтаа хялбараар бүтээ

+70 загваруудаас сонгож вебсайтаа хялбараар угсрах боломжтой **WEBDY** үйлчилгээгээ 50% хямдралтай үнээр аваарай.

УРАМШУУЛЛЫН КОД: WEBDY50



МОНИТОРИНГ болон BACKUP үйлчилгээ

Таны сервер, системийн тасалдалгүй, найдвартай байдлыг хангах **МОНИТОРИНГ** болон **BACKUP** үйлчилгээ эхний сар 100% үнэгүй боллоо.

УРАМШУУЛЛЫН КОД: Monitoring100
Backup100



АГУУЛГА

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	6
< 2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД	7
< АЙТҮҮЛС ХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН/ШИНЖИЛГЭЭ	11
< АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ	32
 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН МАТЕРИАЛ	 35
< ХЭХ-ЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ	36
< ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ	38
< КОМПАНИЙН 2024 ОНЫ АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ТОГТООЛ	41
< ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ҮР ДҮНД ХИЙСЭН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ	42
< ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА	43
< ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	45
< АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСВИЙН САНАЛ	47
< ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД	48
< ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД	58
< АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ	61
< САНАЛЫН ХУУДАС, АШИГЛАХ ЗААВАР	63
 ДАТА ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИЙН ЧИГ ХАНДЛАГА	 66
< КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	67
< ЯАГААД ТАНД PASSWORD MANAGER ХЭРЭГТЭЙ ВЭ?	69
< ТЕХНИКИЙН ДЭМЖЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ	70
< ISO27001 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ	71
< ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ДАТА ТӨВД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	72



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Айтүүлс ХК-ийн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Мэдээллийн технологийн салбар асар хурдацтай хөгжиж, бүхий л зүйлс маш хурдан хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдсээр байгаа энэ цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж олон олон технологийн шийдлүүд, хиймэл оюун ухаанд суурилсан хостингийн үйлчилгээнүүд, клауд технологи зэрэг дэвшилтэт, хэрэгцээт үйлчилгээ бүхий дата төвийн үйл ажиллагаа явуулж буй Айтүүлс ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөөс та бүхэнтэй мэндчилж байгаадаа баяртай байна.

Айтүүлс ХК-ийн бизнесийн үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж, дата төвийн дэд бүтцийн болон системийн найдвартай байдал илтэд сайжран, харилцагчдын сэтгэл ханамж тогтмол өссөөр байна. Улмаар 2024 оны эцсийн байдлаар эрүүл мэнд, боловсрол, санхүү, хөдөө аж ахуй, уул уурхай, мэдээллийн технологийн гэх мэт бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж буй 4,000 гаруй харилцагчдын 18,000 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн байршуулж, хадгалж хамгаалж байна.

Цахим шилжилтийг дэмжих эрх зүйн орчны суурь хуулиуд батлагдаж, Айтүүлс ХК нь Кибер аюулгүй байдлын тухай хуульд тусгайлан заасан үүрэг хариуцлага хүлээсэн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагаар бүртгэгдэн хуулинд заасан нөхцөл шаардлага, өндөр хариуцлагыг хүлээн ажиллаж байгаа билээ.

Цаашид ч бид Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн хувьд, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн дагаж мөрдөх холбогдох хуулиудад заагдсан энэхүү үүрэг хариуцлагыг улам бүр бататган биелүүлж, харилцагч, хамтран ажиллагчид болон хувьцаа эзэмшигчид та бүхний эрх ашгийг дээдлэн, хөрөнгө оруулалтын өгөөжийг өндөр байлгахад анхаарч, компанийн засаглал, ил тод байдлыг хангуулан ажиллах болно гэдгээ та бүхэнд илэрхийлье.

Та бүхэндээ аз жаргал, эрүүл энх хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Г.ХАТАНБОЛД



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Сайн байцаана уу, Та бүхний энэ өдрийн амгаланг эрэн мэндчилье.

Айтүүлс ХК-ийн хамт олон бид нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлууд болон тэдгээрийн үр дүнг танилцуулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зориулан бэлтгэсэн энэхүү тайлангаа хүргэж байгаадаа баяртай байна.

Манай компани сүүлийн жилүүдэд үйл ажиллагаандаа олон улсын ISO 9001:2015, ISO/IEC 27001:2013 стандартуудыг хэвшүүлэн ажилласнаар дата төвийн найдвартай ажиллагааг хангаж, 2024 онд дата төвийн тасралтгүй үйл ажиллагааны хувь 99.997%, тэр дундаа мөн оны 2-р хагас жилд 100%-ийн тасалдалгүй үзүүлэлттэйгээр ажиллалаа.

Ингэснээр дата төвийн үйлчилгээ авч буй харилцагчдын итгэл нэмэгдэж, шинэ хэрэглэгчдийн тоо нэмэгдэн, нэг хэрэглэгчийн Айтүүлс ХК-аас авах үйлчилгээний дундаж тоо 4.53 болж өссөн байна. Мөн сүлжээний шинэ зохион байгуулалтыг хийн, дэлхий нийтийн технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн бүх төрлийн хостинг үйлчилгээний системийг сайжруулан, үйлчилгээний хурдыг нэмэгдүүлж, AI буюу хиймэл оюун ухаанд суурилсан нэмэлт функц бүхий домэйн нэр, и-мэйл, вэб хостингийн боломжуудаар бүтээгдэхүүн үйлчилгээний чанарын сайжруулалтыг хийлээ.

Айтүүлс ХК нь 2024 онд нийт 4,453.3 сая төгрөгийн борлуулалтын орлогыг цуглуулсан ба үүний дотор домэйн нэрийн үйлчилгээний борлуулалтын орлого 17.9%-иар, Клауд үйлчилгээ 50.0%, Техникийн дэмжлэгийн буюу мэргэжсэн систем админы үйлчилгээ 9.9%, Нэмэлт үйлчилгээ 37.0%, Microsoft 365 үйлчилгээний орлого 96.7%-ийн гэх мэтээр өмнөх оны борлуулалтын дүнтэй харьцуулахад өсөлттэй байсан нь нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 13.3 хувиар нэмэгдэхэд нөлөөлжээ. Мөн компанийн цэвэр ашгийн хэмжээ 452.4 сая төгрөгт хүрч цэвэр ашгийн 26.65% буюу нэгж хувьцаанд 3.5 төгрөг, нийт 120.6 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг хэлбэрээр хуваарилах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргалаа.

2025 онд бид цахим орчны мэдээллийн аюулгүй байдалд онцгой анхаарал тавьж, харилцагчид, хамтран ажиллагчдаа мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартын талаар сургалт явуулах, зөвлөгөө өгөх, аудит болон холбогдох үнэлгээ шалгалтыг хийх ажлуудыг төлөвлөсөн ба эдгээр ажлын эхлэл болгон дэлхийн шилдэг бүтээгдэхүүний нэг болох Bitdefender хамгаалалтын нэгдсэн системийг зах зээлд борлуулж эхэллээ.

Цаашид кибер аюулгүй байдал нь дата төвүүдийн гол анхаарах асуудал болох бөгөөд бид аюулгүй байдлын шинэ технологиудыг нэвтрүүлж, аюул заналыг урьдчилан илрүүлэх, хамгаалах арга хэмжээг байнга хэрэгжүүлж, дижитал орчны үнэ цэнийг хүчирхэгжүүлэх найдвартай суурь болох эрхэм зорилгыг тавин ажиллаж байна.

Эцэст нь хувьцаа эзэмшигчид, эрхэм түншүүд, харилцагч та бүхэндээ хамт олныхоо зүгээс талархал илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсье.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал

Чимэдхишигийн Мөнхжаргал

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

➤ **ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын МАГАДЛАН АУДИТ амжилттай хийгдлээ.**



Дата төв, программ хангамж, мэдээлэл технологийн чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч “Айтүүлс” ХК хэрэглэгчдийн хүлээлтэд хүрсэн чанартай үйлчилгээг хүргэх, сэтгэл ханамжийг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор Олон улсын ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандарт-г 2022 оны 3-р улирлаас эхлэн шат дараатай нэвтрүүлэн 2023 оны 2 сард албан ёсны гэрчилгээгээ гардан авсан билээ. Чанарын менежментийн тогтолцооны стандартын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Олон улсын сургалт, баталгаажуулалтын Мон Майнинг Сертификейшин ХХК-аас 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Айтүүлс ХК-д Магадлан Аудит хийсэн бөгөөд аливаа үл тохиролгүй, Сайн гэсэн үнэлгээтэйгээр гэрчилгээгээ үргэлжлүүлэн эзэмших дүгнэлт гарлаа.

➤ **Айтүүлс ХК нь Мэдээлэл, Холбооны Технологийн сургуулийн “Ажил олгогчдын өдөрлөг-2024” арга хэмжээнд амжилттай оролцлоо.**

Дата төв, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч Айтүүлс ХК нь шинэ төгсөгч оюутнуудад ажиллах боломж олгох, компанийн мэдээллээр хангах зорилгоор ШУТИС-ийн МХТС-ийн “Ажил олгогчдын өдөрлөг-2024”-д амжилттай оролцлоо. Уг арга хэмжээний үеэр манай компанид ажилладаг ШУТИС-ийн төгсөгчдийг төлөөлөн Техник үйл ажиллагааны хэлтсийн менежер, Тэргүүлэх аудитор Ч.Гансүлд болон Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Д. Билэгжаргал нар ажлын байрны шалгаруулалтад анкетыг нь хүлээн авч, суралцагч оюутнуудтай нээлттэй уулзаж, ярилцлаа.



➤ **ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны олон улсын “Тэргүүлэх аудитор”-н гэрчилгээгээ гардан авлаа.**

Дижитал орчны үнэ цэнийг хүчирхэгжүүлэх эрхэм зорилгын хүрээнд дата төв, программ хангамжийн үйлчилгээ үзүүлэгч “Айтүүлс” ХК-н Чанарын менежер Д. Билэгжаргал ISO 9001:2015 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН “Тэргүүлэх аудитор” болж, гэрчилгээгээ гардан авлаа.



Манай компани нь хэрэглэгчдэдээ мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан, тасалдалгүй, чанартай үйлчилгээг хүргэх зорилгоор ISO/IEC 27001:2013 Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо болон ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартуудыг 2023 оноос үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа билээ. Уг стандартуудын хэрэгжилтийг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор Монголын стандарт, чанарын хүрээлэн, Олон улсын BSCIC байгууллага хамтран зохион байгуулсан ISO 9001:2015 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН “Тэргүүлэх аудитор”-н сургалтад Чанарын менежер Д. Билэгжаргал хамрагдан, Олон улсын шалгалтаа амжилттай өгч, гэрчилгээгээ гардан авлаа.

➤ **Айтүүлс ХК нь “Нээлттэй Ирээдүй – Дижитал аймаг” арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар оролцлоо.**



Голомт банкны санаачилгаар 2022 оноос эхлэн зохион байгуулсан “Нээлттэй Ирээдүй – Дижитал аймаг” арга хэмжээ нь технологийн байгууллагуудтай хамтран орон нутагт дижитал шилжилт болон технологийн шинэчлэл, хөгжлийг таниулах зорилготой арга хэмжээ бөгөөд 2022, 2023 онуудад нийт 5 аймагт зохион байгуулсан билээ.


Айтүүлс ХК нь анх 2023 онд “Дижитал Дархан” арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар оролцож байсан бол 2024 онд Дархан, Эрдэнэт, Хөвсгөл, Өмнөговь аймгуудад зохиогдсон арга хэмжээнүүдэд амжилттай оролцлоо.

Тус арга хэмжээний үеэр нийтдээ 4 аймгийн 3500 иргэд болон албан байгууллагуудад 40 гаруй мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулсан үзэсгэлэн зохион байгуулсан юм.

Мөн арга хэмжээний хүрээнд Дижитал шилжилтийн талаар мэргэжилтнүүдийн сонирхолтой илтгэлүүд болон нээлттэй хэлэлцүүлгүүд амжилттай болж өрнөлөө. 2024 оны хувьд “SME сургалт, бизнес уулзалт” хийх онцлогтойгоор орон нутгийн бизнес эрхлэгч нартаа хүрч ажиллах зорилгын хүрээнд нийтдээ 200 орчим жижиг, дунд бизнес эрхлэгчдэд сургалт орж, харилцан туршлага солилцсон юм.

Эрдэнэт, Дархан хотуудад 2 дох удаа, Хөвсгөл болон Өмнөговь аймагт анхны удаа зохион байгуулсан уг арга хэмжээ шинэ боломж, үүд хаалгыг иргэд болон жижиг, дунд бизнес эрхлэгч нарт нээж чадсан хэмээн харж байна.

➤ **Нийгмийн хариуцлагын хүрээнд**



Айтүүлс ХК нь дата төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тасралтгүй хийсээр ирсэн ба дата төвийн үйл ажиллагаандаа ашиглаж байсан тоног төхөөрөмжийг шаардлага бүхий сургууль болон ТББ-уудад хандивладаг билээ.

2024 онд 9 төрлийн 22 ширхэг сервер тоног төхөөрөмжийг Мандах дээд сургууль, NEST IT School болон бусад компани, хувь хүмүүст хандивлалаа. Ингэснээр МТ-ийн чиглэлээр суралцаж байгаа оюутан залуус сервертэй танилцах, бодитоор туршин ажиллаж үзэх боломжийг олгосон.

Бид уг ажлыг 2025 онд ч үргэлжлүүлэх тул шаардлага бүхий сургууль, эмнэлэг болон ТББ-ууд холбогдон хандиваар сервер, тоног төхөөрөмжүүдийг авах боломжтой юм.

➤ **iFintech 2.0 арга хэмжээний дэмжигч байгууллагаар ажиллалаа**




Айтүүлс ХК нь Интеллигент Финанс ХХК-аас зохион байгуулсан iFintech 2.0 арга хэмжээний дэмжигч байгууллагаар хамтран ажиллаа. Тус арга хэмжээ нь Монголын банк бус санхүүгийн зах зээлд туршигдсан, байгууллагын мэдээллийн нууцлалыг найдвартай хамгаалах шинэлэг бүтээгдэхүүнүүдийг нийтэд санал болгож, ББСБ бүрд хүртээмжтэй, олон улсын

мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандартыг хангасан, зардлыг багасгаж орлогыг нэмэгдүүлэхүйц, богино хугацаанд шууд ашиглахуйц найдвартай Финтек системүүдийг нийтэд нээлттэй танилцуулах үндсэн зорилготой байсан.

Айтүүлс ХК-ийн хувьд тус арга хэмжээнд дэмжигч байгууллагаар оролцон 40 гаруй Банк бус санхүүгийн байгууллагын 70+ төлөөлөлд компанийн болон бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулгыг хүргэсэн ба Санхүүгийн салбарт хамгаалалтын үйлчилгээ яагаад чухал болох талаар илтгэлийг тавьсан юм.

> **КИБЕР ТУСГААР ТОГТНОЛ II ФОРУМ-д оролцлоо**



Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2024.11.25-ны өдөр “КИБЕР ТУСГААР ТОГТНОЛ II” форумыг зохион байгуулсан. Уг форумгаар Кибер аюулгүй байдлын хууль эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд тулгамдаж буй асуудал, шийдэл, Кибер аюулгүй байдлыг хамгаалах, сөрөн тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх гэсэн хуралдаан, хэлэлцүүлгийн хүрээнд зохион байгуулагдсан байна.

Айтүүлс ХК нь тус форумд Мэдээллийн аюулгүй байдлын аудит, зөвлөх үйлчилгээгээ танилцуулан оролцлоо.

> **Их өгөгдөл + Хиймэл оюуны үндэсний стратеги арга хэмжээнд оролцлоо.**

Цахим хөгжил инновац, харилцаа холбооны яам /ЦХИХХЯ/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Монгол Улсын их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг Төрийн ордонд зохион байгуулсан билээ. Энэ удаагийн хэлэлцүүлгээр тус салбарын болон хиймэл оюун ухааныг өөрсдийн ажил, бизнесийн үйл ажиллагаандаа ашиглаж буй төр, хувийн хэвшил, ОУ-ын байгууллага, ШУ-ны байгууллагын төлөөллүүд байр сууриа илэрхийллээ.



Үндэсний хэмжээний хиймэл оюунтай болохын тулд үнэн зөв, төр, хувийн хэвслээс цуглуулсан үндэсний их өгөгдөл, түүний суурь бүтцийг бүтээлцэх мэргэжилтнүүд манай улсад хэрэгтэй байгааг оролцогчид онцолж байв.

> **AI Домэйн нэрийн хайлтын системтэй боллоо.**




Айтүүлс ХК нь хиймэл оюун ухааны тусламжтайгаар домэйн нэр санал болгодог системийг нэвтрүүллээ. Энэхүү систем нь таны бизнесийн онцлог, шаардлагад нийцсэн төгс домэйн нэрийг олоход туслах юм. Хэрэглэгчид зөвхөн бизнесийнхээ талаар мэдээлэл оруулснаар, хиймэл оюун ухаан нь хамгийн тохиромжтой домэйн нэрийг санал болгох ба дараах давуу талуудтай.

- < Хурдан: Домэйн нэрийг богино хугацаанд санал болгоно.
- < Тохиромжтой: Таны бизнесийн онцлогт нийцсэн нэрийг сонгоно.
- < Хялбар: Хэрэглэхэд хялбар интерфэйстэй.

Та Айтүүлс ХК-ийн хиймэл оюун ухаанд суурилсан домэйн нэр хайх системийг ашиглан өөрийн бизнест төгс тохирох домэйн нэрээ олоорой.

> **AI + Нэмэлт шинэ функцүүдтэй Бизнес И-Мэйл Про үйлчилгээ**



Орчин үед бизнес эрхлэгчдэд найдвартай, мэргэжлийн түвшний харилцаа маш чухал болж байгаа. Бизнес и-мэйл нь зөвхөн харилцааны хэрэгсэл биш, компанийн нэр хүнд, итгэлцлийг бий болгох гол хүчин зүйл юм.

Техник, технологи хурдацтай хөгжихийн хэрээр хүний ажлын ачааллыг хөнгөвчлөх шийдлүүд гарч ирсээр байна. AI буюу хиймэл оюун ухаан нь асар их хэмжээний өгөгдлийг боловсруулж, хэрэглэгчийн оруулсан мэдээлэлд тохируулан хурдан, оновчтой хариу үйлдэл үзүүлэх боломжтой болсон.

Үүний нэг жишээ бол Айтүүлс ХК-ийн “Бизнес И-Мэйл Про” багц юм. Энэ нь өндөр хамгаалалттай, ухаалаг шийдэл бүхий бизнес и-мэйл үйлчилгээ бөгөөд хиймэл оюун ухааны тусламжтайгаар мэйл бичих боломжтойгоор давуу талтай.

Шинэ боломжууд:

- < **Олон төрлийн хэв маяг** – Мэргэжлийн, энгийн, урам зориг өгөх, хөгжилтэй, итгэл төрүүлэхүйц гэх мэт хэв маягийн сонголттойгоор мэйл үүсгэх боломжтой.
- < **Өндөр түвшний хамгаалалт** – Хувийн болон байгууллагын мэдээллийг найдвартай хадгалж, спам, вирус болон халдлагаас 96% хамгаалдаг.
- < **Бизнесийн нэр хүндийг өсгөх** – @yourcompany.mn домэйн нэртэй мэйл хаяг ашигласнаар харилцагчдад итгэл төрүүлж, мэргэжлийн дүр төрх бий болгоно.
- < **Signature** – Таны мэйл дээрх гарын үсэг бол таныг илэрхийлэх нэрийн хуудас мөн билээ. Та өөрийн бизнесийн онцлогт тохируулан брэндийнхээ өнгөө ашиглан сошиал медиа холбоос, лого, зураг агуулсан гарын үсгээ өөрөө үүсгэх боломжтой.
- < **Sidebar** – Та мэйлийнхээ хажуугийн самбараас цаг агаарын мэдээлэл, дуртай мэдээний сайтууд, өдөр бүрийн шинэ ишлэлүүд, календарь дээрх төлөвлөгөө, сүүлийн нэвтрэлтийн IP хаяг зэрэг чухал мэдээллээ харах боломжтой.
- < **Background, өнгө, харагдац байдал** – хэрэглэгчид өөрийн хүссэнээр харагдац, өнгө, background тохируулах боломжтой.
- < Бид таны ажлыг хөнгөвчлөх ухаалаг, найдвартай, хамгаалалттай шийдлийг санал болгож байна.

**Бизнес И-Мэйл Про –
Илүү ухаалаг, хурдан, аюулгүй**

АЙТУУЛС ХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН/ШИНЖИЛГЭЭ

> 2020 – 2024 онуудын жилийн эцсийн Санхүү байдлын тайлан. /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
ХӨРӨНГӨ					
Эргэлтийн хөрөнгө					
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	174,871	250,133	483,470	340,709	418,618
Дансны авлага	656,548	518,227	693,607	1,183,911	944,379
Татвар, НДШ-ийн авлага	-	-	99	-	-
Бусад авлага	1,531	29,664	17,975	36,417	145,900
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	-	-
Бараа материал	95,317	114,588	145,830	144,636	13,272
Урьдчилж төлсөн зардал тооцоо	146	113,046	36,021	11,414	25,443
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-	-	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	928,413	1,025,658	1,377,002	1,717,086	1,547,611
Эргэлтийн бус хөрөнгө					
Үндсэн хөрөнгө	1,465,431	3,497,289	3,560,937	3,492,123	3,343,717
Биет бус хөрөнгө	91,760	45,443	27,278	26,148	19,340
Биологийн хөрөнгө	-	-	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446	70,446	70,446	80,446	80,446
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-	-	-
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,008,172	-	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,635,810	3,613,178	3,658,661	3,598,717	3,443,503
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,564,223	4,638,835	5,035,663	5,315,803	4,991,114
				-	-
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ					
ӨР ТӨЛБӨР					
Богино хугацаат өр төлбөр					
Дансны өглөг	41,335	115,807	52,892	128,593	94,938
Цалингийн өглөг	551	-	263	-	14,951
Татварын өр	59,989	22,141	174,643	62,779	124,296
НДШ-ийн өглөг	-	-	-	-	3,807
Богино хугацаат зээл	-	-	-	-	-
Хүүний өглөг	-	-	-	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-	-	-	-
Урьдчилж орсон орлого	-	-	36,429	114,335	152,473
Нөөц / өр төлбөр /	-	-	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	-	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-	-	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	101,875	137,948	264,226	305,707	390,465

Урт хугацаат өр төлбөр					
Урт хугацаат зээл	-	997,000	997,000	997,000	238,500
Нөөц / өр төлбөр/	-	-	-	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-	-	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	997,000	997,000	997,000	238,500
Өр төлбөрийн нийт дүн	101,875	1,134,948	1,261,226	1,302,707	628,965
Эздийн өмч					
Төрийн өмч	-	-	-	-	-
Хувийн өмч	1,481,441	1,481,441	1,481,441	1,481,441	1,481,441
Хувьцаат өр төлбөр	-	-	-	-	-
Халаасны хувьцаа	-	-	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	763,115	763,115	763,115	763,115	763,115
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,722	460,722	460,722	460,722	460,722
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг	757,070	798,610	1,069,160	1,307,819	1,656,872
Эздийн өмчийн дүн	3,462,348	3,503,887	3,774,438	4,013,096	4,362,150
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	3,564,223	4,638,835	5,035,663	5,315,803	4,991,114

➤ **2020 – 2024 онуудын жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлан /мянган төгрөгөөр/**

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Борлуулалтын орлого (цэвэр)	3,086,785	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,385,417	2,282,147	1,574,492	2,303,173	2,803,347
Нийт ашиг (алдагдал)	701,367	952,222	972,333	1,574,327	1,100,737
Түрээсийн орлого	19,320	19,545	20,682	52,182	35,545
Хүүгийн орлого	1,048	630	-	-	2,336
Ногдол ашгийн орлого	-	-	-	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-	-	-	-
Бусад орлого	34,740	5,321	4,000	-	24
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-	-	203,683
Ерөнхий ба удирдлагын зардал	508,026	648,967	931,435	1,331,038	420,482
Санхүүгийн зардал	-	-	-	-	239,280
Бусад зардал	18,154	31,198	18,839	2,844	12,091
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,556	2,176	1,506	4,123	2,731
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,911)	(4,302)	-	4,177	681
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	-	-	-
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-	-	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	230,940	295,429	48,248	300,928	266,519
Орлогын татварын зардал	24,909	32,663	6,709	30,377	27,861
Татварын дараах ашиг (алдагдал)	206,031	262,766	41,539	270,551	238,658
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	206,031	262,766	41,539	270,551	238,658
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
Бусад олз (гарз)	-	-	-	-	-
Орлогын нийт дүн	206,031	262,766	41,539	270,551	238,658
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	6.0	7.6	1.2	7.9	6.9

➤ **2020 – 2024 онуудын жилийн эцсийн Мөнгөн урсгалын тайлан. /мянган төгрөгөөр/**

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	2,905,335	2,609,282	3,706,940	3,702,915	4,306,249
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	2,895,476	2,599,509	3,084,785	3,677,188	4,277,949
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	-	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	-	-	-
Буцаан авсан албан татвар	-	-	-	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-	-	-
Бусад мөнгөн орлого	9,859	9,773	622,156	25,727	28,300
Мөнгөн зарлагын дүн (-)	2,729,022	2,309,421	3,223,354	3,345,157	3,445,412
Ажиллагсад төлсөн	269,446	381,183	412,443	565,535	748,492
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	34,302	107,054	118,710	164,847	215,477
Бараа материал худалдан авахад төлсөн	2,091,929	1,428,449	2,063,290	1,769,774	1,690,743
Ашиглалтын зардалд төлсөн	2,849	44,965	134,792	186,578	183,694
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	1,696	8,448	5,447	4,560
Хүүний төлбөрт төлсөн	-	105,240	191,280	64,476	55,714
Татварын байгууллагад төлсөн	152,838	93,058	100,943	475,940	430,990
Даатгалын төлбөрт төлсөн	450	-	-	3,322	3,669
Бусад мөнгөн зарлага	177,207	147,776	193,448	109,237	112,073
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	176,314	299,861	483,586	357,758	860,837
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	1,149,089	409,645	625,130	136,297	149,761
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-	20,320	300	10,900
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-	-	110	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,148,459	409,645	604,810	133,551	124,920
Хүлээн авсан хүүний орлого	630	-	-	2,336	13,941
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	1,199,506	1,591,418	869,983	639,738	738,622
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	1,478,455	319,433	324,589	537,872
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-	5,599	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	-	10,000	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,199,506	112,964	550,549	299,550	200,750
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,417)	(1,181,774)	(244,853)	(503,441)	(588,861)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	116,876	1,043,000	74,162	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	114,365	1,043,000	74,162	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	-	-	-
Төрөл бүрийн хандив	-	-	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,511	-	-	-	-

Мөнгөн зарлагын дүн (-)	142,450	87,335	82,100	-	194,806
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	142,265	87,335	82,100	-	140,000
Санхүүгийн түрээсийн өглөлт төлсөн	-	-	-	-	-
Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-	-	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-	-	-	54,806
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	185	-	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(25,574)	955,665	(7,938)	-	(194,806)
Валютын ханшийн зөрүү		1,509	2,542	2,922	739
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	100,322	75,261	233,337	(142,761)	77,909
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,549	174,871	250,133	483,470	340,709
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	174,871	250,133	483,470	340,709	418,618

➤ **2024 оны жилийн эцсийн Өмчийн өөрчлөлтийн тайлан. /мянган төгрөгөөр/**

No	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриглагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441	-	763,115	460,722	-	-	1,069,160	3,774,438
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	238,658	238,658
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441	-	763,115	460,722	-	-	1,307,818	4,013,096
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	452,409	452,409
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(103,356)	(103,356)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441	-	763,115	460,722	-	-	1,656,872	4,362,149

Санхүү байдлын тойм

> Баланс

2024 оны эцсийн байдлаар компанийн нийт хөрөнгө 5 тэрбум төгрөг байсан бөгөөд энэ үзүүлэлт 2023 онд 5.3 тэрбум, 2022 онд 5 тэрбум байсан байна.


Нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн харьцаа 2020-2022 онуудад дунджаар 25% байсан бол сүүлийн 2 жил эргэлтийн хөрөнгийн хувь нэмэгдэж 2024 онд 31%, 2023 онд 32% болсон байна. Энэ нь ихэвчлэн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна. Компанийн хөрөнгийн бүтцийг харахад 2021 оноос нийт өр төлбөр ойролцоогоор 25% байсан бол 2024 онд буурч 13% болсон байна. Үүнд урт хугацаат өр төлбөрийг төлж барагдуулсан нь нөлөөлсөн бөгөөд 2024 онд урт хугацаат өр төлбөрийн хэмжээ 997 саяаас 238.5 сая болж буурсан байна.

Дараах диаграмуудаас компанийн хөрөнгийг санхүүжүүлж буй эздийн өмч, өр төлбөрийн хувь хэмжээ хэрхэн өөрчлөгдсөнийг мөн нийт хөрөнгө болоод өр төлбөр эздийн өмчийн хэмжээ болон бүтэц 2021-2024 онуудад хэрхэн өөрчлөгдсөнийг харж болно.




Компанийн хөрөнгийн бүтэц буюу нийт хөрөнгийн хэдэн хувийг эздийн өмч, өр төлбөрөөр санхүүжүүлж ирснийг 3 жилээр харьцуулсан харьцуулалт

Нийт хөрөнгийн бүтэц



Өр төлбөр ба эздийн өмч




Нийт хөрөнгө ба өр төлбөр, эздийн өмчийн бүтцийг 4 жилээр харьцуулан харууллаа.

> Орлогын тайлан

2024 оны хувьд борлуулалтын орлого өмнөх онынхоос 13% өссөн, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 5% өссөн үзүүлэлттэй байна. 2023 онд борлуулалтын орлого 3.9 тэрбум төгрөг байсан 2024 онд 4.4 тэрбум болж өсчээ.

Борлуулалтын орлогод хамгийн өндөр хувь эзэлж буй үйл ажиллагаа нь cloud.mn, VPS болон домэйн нэрийн үйлчилгээ байна. Борлуулалтын орлого болон ББӨ нэмэгдэж, Ахиуц ашиг өмнөх онынхоос 34% өссөн үзүүлэлттэй байна. Харин цэвэр ашгийн хувьд өнгөрсөн жил 238 сая төгрөг байсан бол энэ жил 452 саяын ашигтай ажиллаж, 90% өссөн байна.

Доорх хүснэгтэд борлуулалтын орлого, ББӨ, үйл ажиллагааны зардал (ерөнхий ба удирдлагын зардал) болон цэвэр ашгийн 2024 оны үзүүлэлт, 2023 онтой харьцуулахад хэдэн хувиар өөрчлөгдсөнийг 5 жилийн трендийн хамт харуулж байна.



Борлуулалтын орлого, ББӨ, цэвэр ашгийн сүүлийн 3 жилийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	(2020)	(2021)	(2022)	(2023)	Тайлангийн жил (2024)	% Өөрчлөлт	5 жилийн тренд
Борлуулалтын орлого	₮ 3,234,368.65	₮ 2,546,825.20	₮ 3,877,499.80	₮ 3,904,084.00	₮ 4,424,958.00	↑ 13%	
ББӨ	₮ 2,282,146.79	₮ 1,574,491.90	₮ 2,303,172.60	₮ 2,803,347.00	₮ 2,949,326.00	↑ 5%	
Ахиуц ашиг	₮ 952,221.86	₮ 972,333.30	₮ 1,574,327.20	₮ 1,100,737.00	₮ 1,475,632.00	↑ 34%	
Үйл ажиллагааны зардал	₮ 648,966.83	₮ 931,434.70	₮ 1,331,037.60	₮ 636,256.00	₮ 833,693.00	↑ 31%	
Үйл ажиллагааны ашиг	₮ 303,255.02	₮ 40,898.60	₮ 243,289.60	₮ 464,481.00	₮ 641,939.00	↑ 38%	
Үйл ажиллагааны бус орлого	₮ 19,545.45	₮ 20,681.80	₮ 52,181.80	₮ 37,881.00	₮ 53,305.00	↑ 41%	
Татварын өмнөх ашиг	₮ 295,428.57	₮ 48,248.10	₮ 300,927.70	₮ 266,519.00	₮ 517,600.00	↑ 94%	
Цэвэр ашиг	₮ 262,765.95	₮ 41,539.40	₮ 270,550.60	₮ 238,658.00	₮ 452,409.00	↑ 90%	

Орлогын тайлангийн 5 жилийн үзүүлэлтүүд болон тренд

> **Мөнгөн гүйлгээний тайлан**

2024 онд үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 861 сая, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ -589 сая, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ -195 сая байжээ.

Үндсэн үйлд ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нь өнгөрсөн онтой харьцуулахад 141% өсч, 358 саяас 860 саяд хүрсэн байна. 2024 онд үндсэн хөрөнгө эзэмших болон бусдад олгосон зээл болон урьдчилгаа төлбөр төлсөн шалтгаанаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ -589 сая байсан байна.

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний хувьд зээл болон ногдол ашиг төлснөөс шалтгаалан -195 сая гарсан байна.

Доорх хүснэгтээс мөнгөн гүйлгээний үзүүлэлтүүд нь 2018-2020 онуудын хооронд ямар дүнтэй байсныг харж болно.

Үзүүлэлтүүд	(2020)	(2021)	(2022)	(2023)	Тайлангийн жил (2024)	% Өөрчлөлт	5 жилийн тренд
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	₮ 176,313.78	₮ 299,860.80	₮ 483,586.30	₮ 357,758.00	₮ 860,837.00	↑ 141%	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-₮ 50,417.50	-₮ 1,181,773.60	-₮ 244,852.60	-₮ 503,441.00	-₮ 588,861.00	↑ 17%	
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-₮ 25,573.92	₮ 955,665.20	-₮ 7,937.90	-	-₮ 194,806.00		

Эх үүсвэрийн бүтээмжийн шинжилгээ

Бүтээмжийн харьцаанууд нь компани өөрийн хөрөнгө, эх үүсвэрүүдээ хэр бүтээмжтэйгээр ашиглан, удирдаж буйг хэмждэг. Өөрөөр хэлбэл, бүтээмжийн харьцаанууд нь (үйл ажиллагааны харьцаа гэж мөн нэрлэгддэг) компани янз бүрийн хэлбэрээр байршсан хөрөнгө эх үүсвэрүүдээ хэр хурдан хугацаанд эргэлтэнд оруулан борлуулалт, мөнгөн орлого болгон хувиргаж буйг хэмжихэд хэрэглэгддэг.

Эдгээр харьцаанууд нь компанийн үргэлжилж буй үйл ажиллагаа хэр бүтээмжтэй байгааг үзүүлэх ба бүтээмжийн харьцаагаар бид авлага өглөгийн эргэц, төлөгдөх хугацаа, бараа материалын эргэц болон ажлын капитал, нийт хөрөнгө зэрэг нь хэр хурдан борлуулалт, орлого болон хувирч буйг харж болно.

Үйл ажиллагааны бүтээмжийг хэмжих үүднээс дараах бүтээмжийн харьцаануудыг тооцож үзлээ. Үүнд:


- < Ажлын капиталын эргэц
- < Эргэлтийн бус хөрөнгийн эргэц
- < Нийт хөрөнгийн эргэц
- < Үйл ажиллагааны мөчлөг (Мөнгөний хөрвөх мөчлөг)

> Авлагын эргэц болон авлага цуглуулах хугацаа

Авлагын эргэц нь компани харилцагч, үйлчлүүлэгчдээс авлагаа хэр сайн цуглуулж, борлуулалт хийгдсэнээс эхлээд, авлага мөнгө болон орж ирэхэд хэр хугацаа зарцуулж буйг хэмждэг. Өөрөөр хэлбэл тухайн тайлант хугацааны дундаж авлага нь хэдэн удаа мөнгөн орлого/борлуулалт болон хөрвүүлэгдсэн болохыг хэмждэг. Авлагын эргэц өндөр байх нь компанийн авлага цуглуулах үйл явц хэр үр дүнтэй байгааг, компанийн харилцагч нар хэр найдвартай, авлага хэр чанартай байгааг илэрхийлдэг.

2024 онд борлуулалтын орлоготой харьцуулахад дундаж авлагын эргэц нь 4.16, авлага цуглуулах хугацаа нь 88 хоног байсан байна. Энэ нь өнгөрсөн жилээс өөрчлөгдөөгүй байна. Компани авлагаа дунджаар 88 хоногт цуглуулж байгаа бөгөөд үүнийг өглөгийн эргэцтэй харьцуулвал удаан байна. 2024 оны хувьд дансны авлагын эцсийн үлдэгдэл өнгөрсөн онынхоос 20%-р буурч 1.2 тэрбумаас 944 сая болсон байна.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Борлуулалтын орлого	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084	4,424,958
Дундаж дансны авлага	919,703	587,387	605,917	938,759	1,064,145
Авлагын эргэц	3.52	4.34	6.40	4.16	4.16
Авлага цуглуулах хугацаа	104	84	57	88	88




> Өглөгийн эргэц болон төлбөр төлөх хугацаа

Өглөгийн эргэцийн харьцаа нь компани тухайн тайлангийн хугацаанд хэдэн удаа, хэр хугацаанд дансны өглөгөө төлж барагдуулсныг үзүүлдэг.

Доорх хүснэгтээс 2020-2024 онуудын ББӨ, дундаж дансны өглөг болон өглөгийн эргэц, өглөг барагдуулах хугацааны үзүүлэлтүүдийг харуулж байна. 2020 онд өглөгийн эргэц удаан, дансны өглөг барагдуулах дундаж хугацаа 60 хоног байсан бол 2021 оноос эхлэн эргэц сайжирч, дунджаар 14 хоногт өглөг барагдуулдаг болсон байна.

Энэ харьцааг авлагын эргэц болон авлага барагдуулах хугацаатай хамтруулан авч үзэхэд хэдийгээр өглөг барагдуулах хугацаа хурдан, эргэц сайн байгаа ч нөгөө талдаа өр төлбөрөө барагдуулж буй хурдтай ижил төстэй хугацаанд авлагаа цуглуулах нь компанийн хөрвөх чадварыг сайжруулахад нөлөөлөх юм. 2020 оны хувьд дунджаар өглөгийг 14 хоногт төлж барагдуулж байхад авлагаа 88 хоногт буюу өглөгтэй ижил хурдтайгаар барагдуулж чадахгүй байгаа нь анхаарууштай гэж үзэж байна.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
ББӨ	2,282,147	1,574,492	2,303,173	2,803,347	2,949,326
Дундаж дансны өглөг	375,954	78,571	84,349	90,742	111,765
Өглөгийн эргэц	6.07	20.04	27.31	30.89	26.39
Дансны өглөг барагдуулах хугацаа	60	18	13	12	14




> Цэвэр эргэлтийн хөрөнгийн (ажлын капиталын) эргэц

Цэвэр эргэлтийн хөрөнгө буюу ажлын капитал нь эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн бөгөөд богино хугацааны өр төлбөрөө барагдуулсны дараа үлдэж буй компанийн эргэлтийн хөрөнгө юм. Ажлын капиталын эргэц нь компани цэвэр эргэлтийн хөрөнгөөрөө борлуулалт/орлого олох үйл явц хэр бүтээмжтэй байгааг илэрхийлдэг. Өөрөөр тайлбарлавал, уг харьцаа нь нэгж төгрөгийн ажлын капитал тутамд хэдэн төгрөг орлого орж ирж буйг харуулна. Тиймээс уг харьцаа өндөр байх нь компани эргэлтийн хөрөнгө, болон богино хугацаат хөрөнгийн эх үүсвэрээ борлуулалтыг дэмжихэд үр дүнтэй, сайн ашиглаж чадаж байгааг, харин энэ харьцаа бага байх нь үр дүнтэй ашиглаж чадахгүй байгааг илэрхийлэх юм.

Доорх хүснэгт, графикаас харахад ажлын капиталын эргэц 2024 онд 2023 онынхоос өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд дунджаар 1.28 тэрбум төгрөгийн ажлын капиталаар 4.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого үүсгэж ажилласан байна. Харин 2023 онд ажлын капиталын эргэц 3.1 байсан буюу 1.26 тэрбумын ажлын капиталыг ашиглан 3.9 тэрбумын борлуулалт хийсэн байна. Энэ нь ажлын капиталын бүтээмж өнгөрсөн оноос 11%-р өссөн үзүүлэлт юм.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Борлуулалтын орлого	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084	4,424,958
Дундаж ажлын капитал	675,703	857,124	1,000,243	1,262,078	1,284,263
Ажлын капиталын эргэц	4.79	2.97	3.88	3.09	3.45




> Эргэлтийн бус хөрөнгийн эргэц

Эргэлтийн бус хөрөнгийн эргэц нь компани эргэлтийн бус хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтаараа хэр үр дүнтэй орлого/борлуулалт үүсгэж байгааг хэмждэг. Өндөр харьцаа нь эргэлтийн бус хөрөнгийг илүү бүтээмжтэйгээр ашиглаж буйг илтгэдэг. Үүнээс гадна, уг харьцаа бага байх нь барилга, үйлдвэр тоног төхөөрөмж гэх мэт үндсэн хөрөнгөд илүү суурилсан бизнесийн орчин, сүүлийн жилүүдэд үндсэн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгөнд чиглэсэн хөрөнгө оруулалт их байсныг, тэдгээр нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж хангалттай орлого үүсгэх хугацаа, нөхцөл хараахан бүрдэж амжаагүй байгааг мөн илтгэх боломжтой.

Доорх хүснэгт, графикаас харахад 5 жилийн дундаж эргэлтийн бус хөрөнгийн эргэц 1.13 байсан бөгөөд 2021 онд 0.82 болж буурсан нь cloud.mn-ий хөрөнгө оруулалтад зориулан серверийн тоног төхөөрөмж худалдан авсан, мөн 2021 оны ковидтой холбоотойгоор борлуулалтын орлого буурсантай холбоотой байна. Сүүлийн 3 жилд эргэц хурдасч энэ жилийн хувьд өнгөрсөн онтой харьцуулахад 17% сайжирсан байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Борлуулалтын орлого	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084	4,424,958
Дундаж цэвэр эргэлтийн бус хөрөнгө	2,655,262	3,124,494	2,994,669	3,628,689	3,521,110
Эргэлтийн бус хөрөнгийн эргэц	1.22	0.82	1.29	1.08	1.26




> Нийт хөрөнгийн эргэц

Нийт хөрөнгийн эргэц нь тухайн компани нийт хөрөнгөө ашиглан орлого үүсгэх чадварыг хэмждэг. Уг харьцаа нь нэгж төгрөгийн хөрөнгө хичнээн хэмжээний орлого үүсгэж буйг хэмждэг.

2024 оны хувьд нийт хөрөнгийн эргэц 14%-р өсч 0.86 болсон бөгөөд 5 жилийн дунджийг авахад эргэц 0.8 байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Борлуулалтын орлого	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084	4,424,958
Дундаж нийт хөрөнгө	3,935,492	4,101,529	4,096,455	5,175,733	5,153,459
Нийт хөрөнгийн эргэц	0.82	0.62	0.95	0.75	0.86



> **Үйл ажиллагааны мөчлөг (Мөнгөний хөрвөх мөчлөг)**

Үйл ажиллагааны мөчлөг (мөнгөний хөрвөх мөчлөг) нь үр ашгаас гадна хөрвөх чадварын хэмжигдэхүүн гэж тооцогддог бөгөөд энэ нь компани бараа материал болон бусад богино хугацаат нөөцөд оруулсан эргэлтийн хөрөнгөө, борлуулалтын мөнгөн орлогод хөрвүүлэхэд (төлбөр цуглуулах) хэр их хугацаа зарцуулж буйг илэрхийлдэг. YAM богино байх нь тухайн компани илүү бүтээмжтэй ажиллаж байгааг, мөн хөрвөх чадвар сайтай байгааг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, бараа бүтээгдэхүүнээ борлуулах чадвар өндөр (авлага цуглуулах хугацаа богино), бараа материалыг эргэлдүүлэхдээ хурдан (бараа материалын агуулахын насжилт богино), мөн нийлүүлэгчдэд төлөх дансны өглөг төлөх хугацаа яаралтай биш (дансны өглөгийн төлбөр төлөх хугацаа нь тодорхой хэмжээгээр харьцангуй урт) байх нь тухайн компанийн хөрвөх чадвар сайн, үйл ажиллагааны бүтээмж өндөр болохыг илтгэнэ.

Доорх хүснэгтэд 2020-2024 онуудын үйл ажиллагааны мөчлөгийг харууллаа. 2024 оны хувьд агуулахын насжилт маш бага буюу компани бараа материалд суурилсан бизнес хийдэггүйг илэрхийлж байна. Харин авлага цуглуулах хугацаа харьцангуй урт буюу 88 өдөр, өглөг барагдуулах хугацаа харьцангуй богино буюу 14 хоног байна. Энэ нь компани богино хугацаат эх үүсвэрүүдээ 76 хоногийн дотор хөрвүүлэн борлуулалтын орлого болгон хувиргаж байна. Өнгөрсөн онд үйл ажиллагааны мөчлөг 95 хоног байсан бөгөөд энэ нь 2024 онд уг үзүүлэлт 20%-р сайжирсан болохыг харуулж байна.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Агуулахын насжилт	15	27	23	19	2
Авлага цуглуулах хугацаа	104	84	57	88	88
Өглөг барагдуулах хугацаа	60	18	13	12	14
Үйл ажиллагааны мөчлөг (өдөр)	59	93	67	95	76

Ашигт ажиллагааны шинжилгээ

Энэхүү шинжилгээний хүрээнд борлуулалтын ашгийн хэмжигдэхүүнүүд (маржин харьцаанууд) болон хөрөнгө оруулалтын ашигт ажиллагааны өгөөжийн хэмжигдэхүүнүүдийг (өгөөжийн харьцаанууд) тооцсон. Эдгээр харьцаанууд нь компанийн орлого, үйл ажиллагааны зардал, балансын хөрөнгүүд, өмч гэх зэрэг үзүүлэлтүүдтэй харьцуулахад хэр их ашигтай ажиллах чадвартай болохыг илэрхийлдэг. Товчхондоо компани одоо байгаа хөрөнгөө хэр үр ашигтай ажиллуулж байгааг харуулдаг.

Ашигт ажиллагааны шинжилгээнд дараах харьцаануудыг тооцсон болно. Үүнд:

- < Нийт ашгийн маржин
- < Цэвэр ашгийн маржин
- < Нийт хөрөнгийн өгөөж
- < Эздийн өмчийн өгөөж
- < ДюПон шинжилгээ
- < Нэгж хувьцаанд ногдох ашиг /алдагдал/ ба P/E харьцаа

> Нийт ашгийн маржин (Gross Profit Margin)


Нийт ашгийн маржин нь тухайн компани ББӨ-өө төлсний дараа үйл ажиллагааны зардал болон бусад зардлуудаа санхүүжүүлэх, ашиг олоход хэрэглэх борлуулалтын орлогын үлдэгдэл юм. Нийт ашгийн маржин бусдаас харьцангуй өндөр байх нь тухайн компанийн үнэ тогтоох чадлыг (харьцангуй өндөр үнээр борлуулалт хийх чадвар) болон бүтээгдэхүүний өртөг буурч байгааг илтгэдэг. Тиймээс энэ харьцаа компанийн өрсөлдөх чадвар нь үнэ тогтоох чадал болон бүтээгдэхүүний өртгийн хувьд хэр байгаа талаар ойлголт өгдөг.

Доорх хүснэгтээс үзэхэд 2024 онд нийт ашгийн маржин 33% байсан. Өнгөрсөн онд уг үзүүлэлт нь 28% байсан бөгөөд 2024 онд өртөг нэмэгдсэнтэй холбоотойгоор зарим үйлчилгээний үнийг нэмсэн нь нийт ашгийн маржиныг нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Өнгөрсөн онд нийт ашиг 1.1 тэрбум байсан бол 2024 онд ойролцоогоор 1.5 тэрбум болж 34%-р өссөн байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2020	2021	2022	2023	2024
Нийт ашиг	952,222	972,333	1,574,327	1,100,737	1,475,632
Борлуулалтын орлого	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084	4,424,958
Нийт ашгийн маржин	29%	38%	41%	28%	33%




> Үйл ажиллагааны ашгийн маржин (Operating Profit Margin)

Үйл ажиллагааны ашгийн маржин нь нийт ашгаас үйл ажиллагааны зардлуудаа санхүүжүүлсний дараа ямар ашигтай ажиллаж байгааг үзүүлэх ба үндсэн үйл ажиллагаанаасаа ямар ашиг бий болгон ажиллаж байгааг харуулдаг.

Цэвэр ашгийн маржин нь 2024 онд үйл ажиллагааны ашгийн маржин 16% байсан бөгөөд үйл ажиллагааны ашиг өмнөх оноос 39% өссөн, 2021 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

Энэ нь компанийн үндсэн үйл ажиллагаа илүү тогтвортой, бүтээмжтэй болж байгааг харуулж байна.

Үзүүлэлтүүд	2020	2021	2022	2023	2024
Үйл ажиллагааны ашиг	297,554	46,742	292,628	502,387	700,148
Борлуулалтын орлого	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084	4,424,958
Үйл ажиллагааны ашгийн маржин	9%	2%	8%	13%	16%




> Цэвэр ашгийн маржин (Net Profit Margin)

Цэвэр ашгийн маржин нь 2024 онд 10% болж, цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн онынхоос 90% өссөн үзүүлэлттэй байна. 2023 онд цэвэр ашиг 239 сая, цэвэр ашгийн маржин 6% байсан бөгөөд энэ жил борлуулалтын орлого өссөн, ББӨ өссөн ч борлуулалтын орлогын өсөлтөөс бага өсөлттэй байсан зэргээс шалтгаалан цэвэр ашгийн маржин өссөн байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2020	2021	2022	2023	2024
Цэвэр ашиг	262,766	41,539	270,551	238,658	452,409
Борлуулалтын орлого	3,234,369	2,546,825	3,877,500	3,904,084	4,424,958
Цэвэр ашгийн маржин	8%	2%	7%	6%	10%



> Нийт хөрөнгийн болон эздийн өмчийн өгөөж

Нийт хөрөнгийн өгөөж нь нийт хөрөнгөтэйгээ харьцуулахад бизнесийн ашигт ажиллагаа хэр байгааг буюу нийт хөрөнгийг хэр үр дүнтэйгээр хэрэглэж байгааг харуулдаг. Өмчийн эздийн өгөөжөөс ялгаатайгаар зөвхөн өмчийн эздэд оногдох өгөөжийг бус өр төлбөрүүдийг багтаадгаараа зээлдүүлэгчдэд оногдох өгөөжийг мөн хэмжинэ.

Эздийн өмчийн өгөөж нь эздийн өмчтэй харьцуулахад бизнесийн ашигт ажиллагаа хэр байгааг буюу эздийн өмчийн 1 төгрөг тутамд ноогдож буй цэвэр ашгийн хэмжээ болно. Энэ харьцаа мөн компанийн хөрөнгийг хэр зөв удирдан зарцуулж, ашиг орлого болгон хувиргаж байгааг илэрхийлдэг.

Доорх хүснэгтүүдээс харахад 2023 онд нийт хөрөнгийн өгөөж 4.61% байсан бол 2024 онд 8.78% болж сайжирсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад өгөөж бараг 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Эздийн өмчийн өгөөж 10.8% болж 2023 оны 6.13%-тай харьцуулахад мөн өссөн дүнтэй байна. 2024 онд урт хугацаат өр төлбөрүүдийг барагдуулан, нийт хөрөнгөд эзлэх өр төлбөрийн хэмжээ буурч, санхүүгийн хөшүүрэг багассанаас үүдэн эздийн өмчийн өгөөж нийт хөрөнгийн өгөөжөөс бага хэмжээгээр өссөн байна. Энэ нь эздийн өмчийн өгөөжийн өсөлтийг бууруулж байгаа мэт харагдаж байгаа ч нөгөө талдаа санхүүгийн эрсдлийг багасгаж байна.

/мянган төгрөгөөр/

	2020	2021	2022	2023	2024
Цэвэр ашиг	262,766	41,539	270,551	238,658	452,409
Нийт хөрөнгө (дундаж)	3,935,492	4,101,529	4,096,455	5,175,733	5,153,459
ROA	6.68%	1.01%	6.60%	4.61%	8.78%

	2020	2021	2022	2023	2024
Цэвэр ашиг	262,766	41,539	270,551	238,658	452,409
Нийт эздийн өмч (дундаж)	3,330,965	3,483,118	3,298,344	3,893,767	4,187,623
ROE	7.89%	1.19%	8.20%	6.13%	10.80%



> ДюПон шинжилгээ

ДюПон шинжилгээгээр эздийн өмчийн өгөөжийг хэд хэдэн түвшинд задлан бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг харгалзах үзэх ба ЭӨӨ-ийн ард чухам ямар хүчин зүйлүүд, яаж нөлөөлж байгааг задалж харуулдаг. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдэд компанийн үр ашигт байдал, бүтээмж, санхүүгийн стратеги зэрэг үзүүлэлтүүд орно.

ЭӨӨ-ийг задалж шинжлэх нь тайлангийн нэг үеэс нөгөө үеийн хооронд ЭӨӨ өөрчлөгдөж буй цаад шалтгааныг тодорхойлоход чухал ач холбогдолтой бөгөөд, олж авсан мэдээллийг ашиглан ЭӨӨ-ийг сайжруулахын тулд удирдлага аль чиглэлд анхаарал хандуулах талаар ойлголт өгдөг. Доор эздийн өмчийн өгөөжийг гурван шатлалтайгаар задалж тайлбарлахыг зорилоо.

а) ЭӨӨ = Нийт хөрөнгийн өгөөж * Санхүүгийн хөшүүрэг

(Бизнесийн стратеги * Санхүүгийн стратеги)

Дээрх томъёоллын дагуу ЭӨӨ нь компанийн НХӨ болон санхүүгийн хөшүүргийн функц юм. Эдгээр нь тус бүр компанийн бизнесийн стратеги (нийт хөрөнгөө хэр өгөөжтэй ашиглаж байгаа) болон санхүүгийн стратегийг (үйл ажиллагаандаа санхүүгийн хөшүүрэг хэрэглэж байгаа эсэх) илтгэж байдаг. Компани эздийн өмчийн өгөөжөө нийт хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх эсхүл санхүүгийн хөшүүргийг нэмэгдүүлэн, өндөр бүтээмжтэйгээр ашиглах замаар өсгөх боломжтой. 2023 оноос 2024 оны хооронд НХӨ өсөлттэй байсан нь ЭӨӨ өсөхөд нөлөөлсөн байна. Харин санхүүгийн хөшүүрэг нь 2024 оноос 2023 оны хооронд буурсан ч НХӨ-ийн өсөлт өндөр байснаас ЭӨӨ нэмэгдсэн байна.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Нийт хөрөнгийн өгөөж	6.68%	1.01%	6.60%	4.61%	8.78%
Санхүүгийн хөшүүрэг	1.18	1.18	1.24	1.33	1.23
ROE	7.89%	1.19%	8.20%	6.13%	10.80%

б) ЭӨӨ = Цэвэр ашгийн маржин * Нийт хөрөнгийн эргэц * Санхүүгийн хөшүүрэг

(Ашигт ажиллагаа * Бүтээмж * Санхүүгийн стратеги)

ЦАМ нь ашигт ажиллагааг буюу нэгж төгрөгийн борлуулалтаас хэр ашиг гарган авч байгааг хэмждэг. НХЭ нь үйл ажиллагааны бүтээмжийг буюу нэгж хөрөнгөөс хэр их орлого олж байгааг хэмждэг. Санхүүгийн хөшүүрэг нь санхүүгийн стратегийг илэрхийлэх ба өөрөөр хэлбэл урт хугацаат төлбөрийн чадварыг тодорхойлдог. Энэ нь компани эздийн өмчтэйгээ харьцуулахад хэр их хөрөнгөтэй байгааг илтгэдэг.

Доорх хүснэгтээс эздийн өмчийн өгөөжид ашигт ажиллагаа, бүтээмж болон санхүүгийн хөшүүрэг 2020-2024 онуудад хэрхэн нөлөөлснийг харж болно. Үүнээс харахад 2024 онд цэвэр ашгийн маржин 10%, нийт хөрөнгийн эргэц 0.86, санхүүгийн хөшүүрэг 1.23 байсан нь эздийн өмчийн өгөөжийг 10.8% болоход нөлөөлсөн байна. 2023 онд санхүүгийн хөшүүрэг өндөр байсан ч нийт хөрөнгийн эргэц бага, цэвэр ашгийн маржин бага байснаас үүдэн ЭӨӨ бага байсан байна.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Цэвэр ашгийн маржин	8%	2%	7%	6%	10%
Нийт хөрөнгийн эргэц	0.82	0.62	0.95	0.75	0.86
Санхүүгийн хөшүүрэг	1.18	1.18	1.24	1.33	1.23
ROE	7.89%	1.19%	8.20%	6.13%	10.80%

с) $ЭӨӨ = \text{Татварын дарамт} * \text{Хүүний дарамт} * \text{Хүү, татвар төлөхийн өмнөх ашгийн маржин} * \text{Нийт хөрөнгийн эргэц} * \text{Санхүүгийн хөшүүрэг}$

Энэхүү таван хүчин зүйлт задаргаа нь ДюПон шинжилгээний хамгийн детальчилсан хэлбэр юм.

Үүгээр татвар, хүүний төлбөрүүд, ашигт ажиллагаа, үйл ажиллагааны бүтээмж, санхүүгийн хөшүүрэг (өр төлбөр барагдуулах чадвар) гэсэн хүчин зүйлс нь эздийн өмчид хэр нөлөөлснийг тогтоодог.

Дараах хүснэгтийг харвал эздийн өмчийн өгөөжид ямар хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлснийг бид деталиар нь харах боломжтой. 2023, 2024 онуудад татварын дарамт тус бүр 10% болон 13% байсан байна. Хүүний дарамт 2023 онд хамгийн их буюу 47% байсан бөгөөд 2024 онд урт хугцаат өр төлбөрүүдийг төлж барагдуулснаас 26% болж буурсан байна. Хүү болон татварын өмнөх ашгийн маржин нь 2024 онд хамгийн өндөр буюу 16%, 2023 онд 13% байна. Нийт хөрөнгийн эргэц 2023 онд 0.75 байсан бол 2024 онд 0.86 болж өссөн ба санхүүгийн хөшүүрэг 2024 онд буурсан байна. 2024 он ЭӨӨ-ийг нэмэгдүүлсэн гол хүчин зүйлс нь хүүний дарамт буурсан, ашигт ажиллагаа сайжирсан мөн нийт хөрөнгийн эргэц сайжирсантай холбоотой байна.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Татварын дарамт	0.89	0.86	0.90	0.90	0.87
Хүүний дарамт	1.00	1.00	1.00	0.53	0.74
Хүү болон татварын өмнөх ашгийн маржин	0.09	0.02	0.08	0.13	0.16
Нийт хөрөнгийн эргэц	0.82	0.62	0.95	0.75	0.86
Санхүүгийн хөшүүрэг	1.18	1.18	1.24	1.33	1.23
ROE	7.89%	1.19%	8.20%	6.13%	10.80%

> Нэгж хувьцаанд ногдох ашиг/алдагдал/ EPS ба P/E, P/B харьцаа

Нэгж хувьцаанд ногдох ашиг/алдагдал/ EPS болон P/E, P/B харьцаанууд нь потенциал хөрөнгө оруулагчдын хувьд тухайн компанийн үнэ цэнийг тодорхойлоход чухал бөгөөд бусад хувьцаануудтай харьцуулалт хийн, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ач холбогдолтой байдаг. P/E харьцаа нь компанийн санхүүгийн үзүүлэлтээс гадна хувьцааны үнийг авч үзсэнээрээ хөрөнгө оруулагчдын хүлээлтийг, мөн тухайн хувьцаа хэт үнэлэгдсэн байгаа эсэх талаар мөн таамаг өгч байдаг. P/B харьцааны хувьд компанийн нэгж хувьцааны дансны үнийг зах зээл дээрх үнэтэй харьцуулдгаараа тухайн хувьцаа дансны үнээсээ хэт үнэлэгдсэн эсвэл доогуур үнэлэгдсэнийг харуулж байдаг.

2024 оны эцсийн байдлаар нэгж хувьцаанд ногдох ашиг 13.13 төгрөг байсан ба энэ нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Цэвэр ашиг өнгөрсөн онтой харьцуулахад 90% өссөн тул уг харьцаа мөн 90% өссөн үзүүлэлттэй байна.

2024 оны 12 сарын 31 байдлаар хаалтын ханш 79.99 төгрөг байсан бөгөөд P/E харьцаа 6.09 байна. Энэ нь өнгөрсөн оны 10.72-с мөн сайжирсан үзүүлэлт юм.

P/B харьцааны хувьд 2024 оны 12 сарын 31-ны хаалтын ханшаар тооцоход 0.63 буюу 127 төгрөгийн дансны үнэ бүхий хувьцаа 80 төгрөгөөр арилжаалагдаж байна.

/мянгатын орноор товчилсон/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Цэвэр ашиг	262,766	41,539	270,551	238,658	452,409
Хувьцааны тоо	34,452	34,452	34,452	34,452	34,452
EPS	7.63	1.21	7.85	6.93	13.13
Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
EPS	7.63	1.21	7.85	6.93	13.13
Хаалтын ханш (12 сарын 31-ээр)	83	101	69	74	80
P/E харьцаа	10.86	83.73	8.79	10.72	6.09
Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Нийт хөрөнгө	3,564,223	4,638,835	5,035,663	5,315,803	4,991,114
Өр төлбөр	101,875	1,134,948	1,261,226	1,302,707	628,965
Дансны үнэ	100	102	109.6	116	127
Хаалтын ханш (12 сарын 31-ээр)	83	101	69	74	80
P/B харьцаа	0.82	0.99	0.63	0.64	0.63

Дүгнэлт

Санхүүгийн тайланд хийсэн үйл ажиллагааны бүтээмж, эх үүсвэрийн үр ашигт байдал, богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн чадвар зэргийг хэмжих харьцаа, эдгээрийн үр дүнгээс харахад дараах дүгнэлтийг гаргаж болохоор байна. Үүнд:

< Бүтээмж

2020-2024 онуудад бараа материалын эргэцээс бусад бүтээмжийн харьцаанууд ерөнхийдөө тогтвортой байна. 2023, 2024 онуудыг харьцуулахад 2024 онд ажлын капиталын эргэц, эргэлтийн бус хөрөнгийн эргэц, нийт хөрөнгийн эргэц гэх мэт хөрөнгийн бүтээмжийн харьцаанууд бүгд өсөлттэй гарсан байна. 2024 онд үйл ажиллагааны мөчлөг буюу cash conversion cycle мөн сайжирч 76 хоног болон буурсан нь өнгөрсөн оноос 20%-р бүтээмж сайжирсан үзүүлэлт байна. Анхаарал хандуулах шаардлагатай зүйл нь авлагын эргэцийг нэмэгдүүлж, авлага цуглуулах хугацааг багасгах шаардлагатай байна. Авлагын чанарыг тодорхойлж, өглөг авлагын эргэцийг аль болох ойролцоо байлгах нь богино хугацааны хөрвөх чадварыг сайжруулна.

< Ашигт ажиллагаа

Ашгийн маржинууд (үйл ажиллагааны ашиг болон цэвэр ашиг) 2024 онд өмнөх онуудтай харьцуулахад өссөн бөгөөд, 5 жилийн хамгийн сайн үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгө болон эздийн өмчийн өгөөж мөн 2024 онд бусад онуудтай харьцуулахад хамгийн өндөр байгаа нь ашигт ажиллагаа сайжирч байгааг мөн илтгэж байна. 2024 онд эзпийн өмчийн өгөөжийг нэмэгдүүлсэн хүчин зүйлс нь хүүний дарамт багассан, ашигт ажиллагаа сайжирсан, нийт хөрөнгийн эргэц сайжирсантай холбоотой байна.

< Хөрвөх чадвар

Хөрвөх чадварын харьцаануудын хувьд 2021 онд урт хугацаат зээл авч, төлбөрийг 2022 оноос төлж эхэлснээс үүдэн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлсөн харагдаж байгаа ч үзүүлэлтүүд нь сайн байгаа бөгөөд богино хугацаат өр төлбөр төлөх чадвар, хөрвөх чадвар сайн байгааг, мөн богино хугацаат хөрөнгөөр үйл ажиллагаагаа санхүүжүүлэх чадвар хангалттай байгааг харуулж байна.

< Урт хугацаат төлбөрийн чадвар

Компанийн хувьд өмнө нь урт хугацаат өр төлбөргүйгээр үйл ажиллагаа явуулж байсан ч 2021 онд урт хугацаат зээл авсан бөгөөд санхүүгийн хөшүүрэг 2022, 2023 онуудад харьцангуй өндөр байсан. Компанийн төлбөрийн чадвар, хүүний төлбөр төлөх чадвар зэрэг харьцаанууд нь сүүлийн 2-3 жилд сайжирч, 2024 онд хамгийн сайн үзүүлэлттэй байна. Харьцааны үзүүлэлтүүдээс харахад урт хугацаат өр төлбөрийн аливаа эрсдэлд ороогүй бүрэн төлбөрийн чадвартай байгаа нь харагдаж байна.

АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ



“АЙТҮҮЛС” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2025.02.03 № СТА/25-10

танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “АЙТҮҮЛС” ХК-ний 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЭЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.



Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь Шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- ✓ Санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компанид хамаарах аж



“АЙТҮҮЛС” ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлын талаар ярилцсан.

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу “Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2025 оны 02 сарын 03



Д.АЛТАНЦЭЦЭГ
Захирал, ММНБ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН МАТЕРИАЛ



ХЭХ-ЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 12-ны өдөр

Дугаар 25/003

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.1, 60.2, 64-р зүйлийн 64.2, 65-р зүйлийн 65.4, 71-р зүйлийн 71.1, 71.2, 71.3, 76-р зүйлийн 76.1.2, 76.1.3, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.27, 7.31, "Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллаганы журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3-р сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Айтүүлс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4-р сарын 25-ны өдрийн Баасан гарагт 10:00 цагт Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн гудамж-8, Континентал зочид буудал, 2 давхарт байрлах хурлын тэнхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - 2.2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
 - 2.3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.4. Компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
 - 2.5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;
 - 2.6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, сонгох;
 - 2.7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах;
 - 2.8. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4-р сарын 02-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар болон хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалт, бусад холбогдох мэдээллийг Хавсралт 1-ээр баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг Хавсралт 2-оор баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцохгүй ч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсонд тооцох ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 4-р сарын 23-ны өдрийн 13:00 хүртэл байхаар тогтсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Хатанболдыг, Тооллогын комиссын даргаар Х.Уянга /ХҮХ-ийн мэргэжилтэн/, тооллогын комиссын гишүүнээр Х.Аймерей /Маркетингийн мэргэжилтэн/, Э.Тэмүүлэн /Системийн инженер/ нарыг тус тус томилсугай.
8. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга: Д.Жигжид /МБХ-ийн менежер/
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Г.Янжилхам /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/, Б.Өнөрбадрах /Ахлах нягтлан бодогч/, С.Нандинзул /Нягтлан бодогч/
9. Энэхүү тогтоолын шийдвэр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг СЗХ-ноос баталсан "Хувьцаат компанийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлэх, холбогдох талуудад хүргүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.ХАТАНБОЛД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн
25/003 тоот тогтоолын Хавсралт 1

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

№	Хөтөлбөр	Хариуцагч	Үргэлжлэх хугацаа (минут)
1	Хурлын ирц бүртгэх	Зохион байгуулах комисс Тооллогын комисс	9:30 – 10:00
2	Хурлын ирцийг мэдээлэх	Тооллогын комисс	10:00 –10:05
3	Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга	10:05 –10:10
4	Айтүүлс ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах	Гүйцэтгэх захирал	10:10 –10:25
5	Компанийн 2024 оны Санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах	Сэрэлт дөл аудит ХХК	10:25 –10:30
6	Айтүүлс ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	Хурлын дарга	10:30 –10:45
7	ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах		
8	Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг танилцуулах		
9	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг хийх	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга	10:45 –10:55
10	ТУЗ-ийн 2025 оны төсвийг танилцуулах	Хурлын дарга	10:55 –11:25
11	Компанийн дүрэмд орох өөрчлөлтийг танилцуулах		
12	Асуулт, хариулт		
13	Санал хураалт	Тооллогын комисс	11:25 –11:40
14	Хурлын завсарлага, санал тоолох	Зохион байгуулах комисс, Тооллогын комисс	11:40 –12:00
15	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс	12:00 –12:05
16	Хурлаас гарах тогтоолыг танилцуулах	Хурлын дарга	12:05 –12:10
17	Хурлыг хаах		

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг 15 минут
Хурал үргэлжлэх цаг: 10:00-12:15

“АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Айтүүлс” ХК-ийн (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Ээлжит хурал” гэх) нь **2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 10 цаг 00 минутад Монгол улс, Улаанбаатар хот, Юнескогийн гудамж-8, Континентал зочид буудал, 2 давхарт байрлах хурлын тэнхимд хуралдана.**

Ээлжит хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн 2024 оны ашгаас ногдол ашиг хуваарилах талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, сонгох;
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг батлах.
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь **2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр** (“Бүртгэлийн өдөр”) байна.

Саналын хуудсаар саналаа өгөх хувьцаа эзэмшигчдийн Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа **2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 13 цаг 00 минут** байна.

Ээлжит хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп-16, Реженси резиденс, 201 тоот

И-мэйл: secretary@itools.mn

Утас: 75755585, 99059722



“АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, ТҮҮНТЭЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2025 оны 3-р сарын 24-ны өдрөөс эхлэн Айтүүлс ХК-ийн албан ёсны <https://itools.mn/> цахим хуудас эсхүл ажлын өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд “Айтүүлс” ХК-ийн байранд хүрэлцэн ирж дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
4. Айтүүлс ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
5. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт
6. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн хурлын 25/001 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоол
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийн төсөл
9. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд
11. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид, тэдгээрийн танилцуулга
12. Саналын хуудас

КОМПАНИЙН 2024 ОНЫ АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ТОГТООЛ



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 06-ны өдөр

Дугаар 25/001

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.1.1, 46.1.2, 76-р зүйлийн 76.1.12, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийг 7.27, 7.31, "Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллаганы журам"-ын 8 дугаар зүйлийг 8.1, 8.2 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2-р сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 26.65 хувь буюу 120,582,434.00 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд тус бүр 3.5 төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-аар дамжуулан 2025 оны 4 дугаар сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашиг хуваарилах шийдвэрлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
5. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.
6. Ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.ХАТАНБОЛД

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ҮР ДҮНД ХИЙСЭН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

АЙТҮҮЛС ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэгт заасны дагуу Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс Айтүүлс ХК-ийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай танилцаж, дараах дүгнэлтийг гаргав.

Айтүүлс ХК нь 2022 оноос эхлэн үйл ажиллагаандаа олон улсын нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлж, Чанарын менежментийн ISO9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2013 стандартуудыг мөрдөн ажиллаж хэвшсэнээр дата төвийн үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг болон мэдээллийн аюулгүй байдлыг 100% ханган ажиллаж байна.

2024 онд дата төвийн хэмжээнд сүлжээний шинэ зохион байгуулалтыг хийж, нөөц дата төвийг байгуулж бизнесийн тасралтгүй байдал болон гамшгийн үеийн эрсдэлд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн нь сайшаалтай. Үүний зэрэгцээ зах зээл, харилцагчдад нэн чухлаар шаардагдаж буй мэргэжлийн систем администраторын үйлчилгээ болох "Техникийн дэмжлэгийн үйлчилгээ"-г энэ онд нэвтрүүлж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас "Мэдээллийн аюулгүй байдлын аудит" хийх зөвшөөрлийг авснаар харилцагчдад зөвлөгөө, сургалт, нэмэлт үйлчилгээ хүргэх, улмаар нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс 2024 онд анх удаа компанийн санхүүгийн үр дүн, цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3 төгрөгөөр тооцон, нийт 103.4 сая төгрөгийн ноогдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд тараах шийдвэр гаргасан. 2025 онд Айтүүлс ХК нь нийт 4,453.3 сая төгрөгийн борлуулалтын орлогыг цуглуулсан нь өмнөх оноос 524.2 сая төгрөгөөр буюу 13.3%-аар өсч, цэвэр ашгийн хэмжээ 452.4 сая төгрөгт хүрч бизнес төлөвлөгөөнөөс 47.5%-аар давж биелэн, хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг тараах боломжийг дахин бүрдүүлжээ.

Компанийн санхүүгийн тайланд "Сэрэлт дөл аудит" ХХК нь 5 дахь жилдээ хөндлөнгийн аудитыг хийсэн ба Айтүүлс ХК-ийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь холбогдох стандарт, заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн хэмээн дүгнэсэн байна.

Иймд Айтүүлс ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг "Хангалттай" хэмээн дүгнэж байна.


АЙТҮҮЛС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ТУЗ-ИЙН ДАРГА

> Г.Хатанболд

- Санхүүгийн удирдлага, эрх зүйч
- Ай Си Ти групп ХК-ийн Гүйцэтгэх захирал



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН:

> Г.Гантуяа

- Бизнесийн удирдлагын докторант
- Боловсролын үнэлгээний төвийн захирал
- Аудит, мэдээллийн аюулгүй байдлын хорооны дарга
- Бизнес хөгжлийн хороо болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүн




> Н.Жавхлан

- Төрийн удирдлагын магистр
- Могоул Консалтинг сервис ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- Нэр дэвшүүлэх хорооны дарга
- Цалин урамшууллын хороо болон Бизнес хөгжлийн хорооны гишүүн



> З.Саранчимэг

- Эрх зүйн ухааны магистр
- Теста лайфстайл ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- Цалин урамшууллын хорооны дарга
- Аудит, мэдээллийн аюулгүй байдлын хороо болон Бизнес хөгжлийн хорооны гишүүн



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН:

> А.Баттамир

- Техникийн ухааны докторант
- Ай Си Ти групп ХК-ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн
- Бизнес хөгжлийн хорооны гишүүн



➤ **Л. Золбаяр**

- Санхүүгийн менежмент
- Ай Си Ти групп ХК, Хөрөнгө оруулалтын газрын захирал
- Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны гишүүн



➤ **З. Төрболд**

- Санхүүгийн менежмент магистр
- Стандарт инвестмент ҮЦК ХХК Гүйцэтгэх захирал
- Бизнес хөгжлийн хорооны дарга



➤ **Л. Бунчинсүрэн**

- Нягтлан бодогч
- Ай Си Ти групп ХК-ийн Санхүү хариуцсан захирал
- Аудит, мэдээллийн аюулгүй байдлын хорооны гишүүн



➤ **Ч. Мөнхжаргал**

- Бизнесийн удирдлагын магистр
- Айтүүлс ХК-ийн Гүйцэтгэх захирал



ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

➤ **Г.Янжинлхам**

- Нийтийн удирдлага магистр, эрх зүйч



ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 онд **Айтүүлс ХК**-ийн ТУЗ нь компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилгоор, хуульд заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх **Аудит, Мэдээллийн аюулгүй байдлын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо, болон Бизнес хөгжлийн хороо**-г байгуулан амжилттай ажиллалаа.



ТУЗ нь компанийн стратеги төлөвлөгөө, санхүүгийн тайлан, хүний нөөцийн бодлого зэрэг чухал асуудлыг шийдвэрлэхэд Гүйцэтгэх удирдлагын багт дэмжлэг үзүүлэн ажилласан бөгөөд 2024 онд удирдлагын багтай хамтран компани өсөж, тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн төлөө олон чухал алхмуудыг амжилттай хийлээ. Компанийн засаглалын тогтвортой байдлыг хангаж, бизнесийн боломжуудыг нэмэгдүүлэх, өргөжүүлэх стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийг зорин ажилласан.

2. Хороодын үйл ажиллагаа

➤ Аудитын хороо

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайланг хянах, хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, санхүүгийн үйл ажиллагааг дүгнэх үйл ажиллагаа явуулсан. 2024 оны хөндлөнгийн аудитын байгууллага сонгох, санхүүгийн тайланг хянах, үйл ажиллагааны үр дүнг дүгнэх үйл ажиллагаануудыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, шаардлагатай алхмуудыг амжилттай хэрэгжүүлсэн.

➤ Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, шинэ гишүүдийг нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус хороо нь ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнтэй холбогдох бүх үйл ажиллагааг тодорхойлохоос гадна, гишүүдийн олон улсын болон үндэсний туршлага, ур чадварыг харгалзан үзэж нэр дэвшигчдийг шалгаруулсан.

➤ Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын бодлого, гүйцэтгэх захирлын гэрээний нөхцөл зэрэг асуудлуудад анхаарал хандуулж ажилласан. 2024 онд энэ хороо нь гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал, түүний гэрээний нөхцлийг шинэчилж, ТУЗ-ийн гишүүдийн хөлс болон урамшууллыг шударга, тэнцвэртэй тогтоох чиглэлд амжилттай ажилласан.

➤ Бизнес хөгжлийн хороо

Бизнес хөгжлийн хороо нь компанийн бизнес төлөвлөгөө боловсруулах болон компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, борлуулалт стратеги төлөвлөлт дээр Гүйцэтгэх удирдлагын багт зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн ажилласан.

3. ТУЗ-ийн үйл ажиллагаа

ТУЗ нь компанийн бизнесийн стратеги, эрсдлийн удирдлага, санхүүгийн хяналт, тайлагнал, хүний нөөцийн бодлого болон цалин урамшууллын асуудлуудыг улиралд хамгийн багадаа нэг удаа хуралдуулж хэлэлцдэг. Тайлант хугацаанд ТУЗ нь компанийн стратегийн зорилтыг шинэчилж, бизнес төлөвлөгөөг дахин хянаж, Гүйцэтгэх захирлын үүрэг чиглэлүүдийг тодорхойлсон. Мөн ТУЗ нь хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон шалгаруулах, ногдол ашиг хуваарилах тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн үйл ажиллагаа нь компанийн тогтвортой байдлыг баталгаажуулах, бизнесийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар компанийн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн.

4. Хурлуудын товч мэдээлэл

2024 онд ТУЗ нийт 7 удаа ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулсан. Энэ хугацаанд нийт 20 тогтоол гаргасан бөгөөд үүнд:

- < ТУЗ-ийн даргыг томилох
- < ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах
- < Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон шалгаруулах
- < Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах
- < Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах
- < Тооллогын комисс байгуулах
- < Журам батлах зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл явдал

2024 оны 4-р сарын 19-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгуулж, жилийн ажлын тайлан болон бизнесийн стратегийн төлөвлөгөөг танилцуулсан. Хурлын үеэр компанийн гүйцэтгэл, амжилт, тулгарч буй сорилтууд болон ирээдүйн стратегийн төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хувьцаа эзэмшигчдийн санал бодлыг сонссон.

Хурлын үеэр компанийн ирээдүйд хийх гол арга хэмжээ болон хөрөнгө оруулалт, бизнесийн хөгжлийн төлөвлөгөөг дэмжигчдийн саналд тулгуурлан хамтран ажиллах шинэ гарцуудаа тодорхойлсон.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлууд, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлуудаас гадна ХЭЭХ-ийг зохион байгуулах ажлыг хариуцан, ТУЗ-өөс гарсан тогтоол тэмдэглэлийг хөтлөх, хадгалах, МХБ болон СЗХ-нд холбогдох бичиг баримтыг хүргүүлэх чиг үүргээ биелүүлэн ажилласан.

АЙТУҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСВИЙН САНАЛ

№	Үйл ажиллагаа	Жилийн зардал, ₮
1	ТУЗ-ийн хурал түүнтэй холбогдох үйл ажиллагааны зардал	1,000,000₮
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	41,300,000₮
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин, урамшуулал	13,500,000₮
4	Бусад зардал	1,000,000₮
НИЙТ ДҮН		56,800,000₮

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН **ЕРДИЙН ГИШҮҮНД** НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Гантулга**

Өөрийн нэр: **Хатанболд**

Төрсөн он: **1986**

Төрсөн газар: **Хөвсгөл аймаг**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС-ХЗС	Улаанбаатар	2015	2018	Эрх зүйч
2	ШУТИС-КТМС	Улаанбаатар	2003	2007	Санхүү удирдлага
3	Хөвсгөл, Тариалан 10-н жил	Хөвсгөл, Тариалан сум	1994	2003	Бүрэн дунд

Гурав. Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Ай Си Ти групп ХК	Гүйцэтгэх захирал	2020 оноос хойш
2	Стандарт капитал ХХК	Дэд захирал	2012 - 2020
3	Хера холдинг ХХК	Судалгааны ахлах ажилтан	2009-2012
4	Лайфтайм инвестмент ҮЦК ХХК	Брокер, диллер	2007-2008

АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН **ЕРДИЙН ГИШҮҮНД** НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Адилбиш**

Өөрийн нэр: **Баттамир**

Төрсөн он: **1982**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС	Улаанбаатар	2018	-	Докторант
2	ШУТИС- КТМС	Улаанбаатар	2016	2018	Техникийн ухааны магистр
3	ШУТИС-КТМС	Улаанбаатар	1998	2003	Програм хангамж
4	Өсвөрийн зохион бүтээгчдийн төв сургууль	Улаанбаатар	1995	1998	Бүрэн дунд боловсрол

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Ай Си Ти групп ХК	ТУЗ-ийн гишүүн	2021 оноос
2	Ай Си Ти Групп ХК	Технологи хариуцсан захирал	2017-2021
3	Ай Си Ти Групп ХК	Гүйцэтгэх захирал	2013-2017
4	Айтүүлс ХХК	Гүйцэтгэх захирал	2011-2014
5	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам	Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх	2011-2012
6	Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо	Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх	2009-2011
7	Эрчим хүчний диспетчерийн үндэсний төв	Програмист	2002-2009

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН **ЕРДИЙН ГИШҮҮНД** НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Пүрэвсүрэн**
Өөрийн нэр: **Дэлгэрмаа**
Төрсөн он: **1986**
Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-КТМС	Улаанбаатар	2008	2010	Санхүүгийн удирдлага магистр
2	ШУТИС-КТМС	Улаанбаатар	2004	2008	Санхүүгийн удирдлага
3	97-р дунд сургууль	Улаанбаатар	1994	2004	Бүрэн дунд боловсрол

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Ай Си Ти групп ХК	Стратеги, хөрөнгө оруулалтын газрын захирал	2025 оноос
2	Хьюндай моторс Монгол ХХК	Санхүүгийн ахлах менежер	2010 - 2024
3	ШУТИС-КТМС	Гэрээт багш/Микро, макро эдийн засаг, Бизнесийн статистик, Санхүүгийн менежмент	2009 - 2010
4	Лайфтайм Инвэстмент ХХК	Нягтлан бодогч	2008.01- 2008.07

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН **ЕРДИЙН ГИШҮҮНД** НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Зоригтбаатар**

Өөрийн нэр: **Төрболд**

Төрсөн он: **1995**

Төрсөн газар: **Архангай аймаг**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС- Бизнесийн ахисан түвшний сургууль	Улаанбаатар	2021	2022	Санхүүгийн менежмент магистр
2	МУИС- Бизнесийн сургууль	Улаанбаатар	2013	2017	Бизнесийн удирдлага
3	Архангай аймгийн Тамир сумын бүрэн дунд сургууль	Ихтамир	2003	2013	Бүрэн дунд

Гурав. Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Стандарт инвестмент ҮЦК ХХК	Гүйцэтгэх захирал	2020 оноос
2	Мерекс ХК	ТУЗ-ийн гишүүн	2022 оноос

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН **ЕРДИЙН ГИШҮҮНД** НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Дашцэнд**
Өөрийн нэр: **Сарнайцэцэг**
Төрсөн он: **1979**
Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Санхүү эдийн засгийн Их сургууль	Улаанбаатар	2001	2003	Бизнесийн удирдлагын магистр
2	Санхүү Эдийн засгийн Их сургууль	Улаанбаатар	1997	2001	Эдийн засагч - Нягтлан бодогч
3	5-р дунд сургууль	Улаанбаатар	1987	1997	Бүрэн дунд

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Ай Си Ти групп ХК	Санхүүгийн газрын захирал	2024.09 сараас
2	Говь Кашемир ББСБ ХХК	Санхүү удирдлагын албаны дарга	2024.08-2024.09
3	Тус Финтек ББСБ ХХК	Санхүүгийн менежер	2024.03-2024.08
4	Мобиком корпораци ХХК	Ахлах нягтлан, Ахлах эдийн засагч, Ахлах санхүүгийн шинжээч, Team leader	2005-2023
5	Номадс турс Экспедишн ХХК	Нягтлан бодогч	2004-2005

АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН **ЕРДИЙН ГИШҮҮНД** НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Чимэдхишиг**
Өөрийн нэр: **Мөнхжаргал**
Төрсөн он: **1975**
Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Санхүү эдийн засгийн дээд сургууль	Улаанбаатар	2000	2002	Бизнесийн удирдлагын магистр
2	МУИС- Эдийн засгийн сургууль	Улаанбаатар	1992	1996	Эдийн засагч, зах зээл судлаач
3	50-р дунд сургууль	Улаанбаатар	1982	1992	Бүрэн дунд

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Айтүүлс ХК	Гүйцэтгэх захирал	2022 оноос
2	Мобифинанс ББСБ ХХК	Гүйцэтгэх захирал	2018-2019
3	Мобиком корпораци ХХК	Дижитал бизнесийн албаны захирал	2014-2019
4	Мобинет ХХК	Бизнесийн албаны захирал	2009-2014
5	Монгол контент ХХК	Веб порталын хэлтсийн менежер	2007-2009
6	Мобиком корпораци ХХК	Төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн	2005-2007
7	Си Эйч Эф интернэйшнл ХХК	Бизнесийн зөвлөх	2003-2004
8	Мобиком корпораци ХХК	Маркетингийн мэргэжилтэн	2002-2004

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Ганбүргэд**

Өөрийн нэр: **Гантуяа**

Төрсөн он: **1979**

Төрсөн газар: **Төв аймаг**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-БАТС	Улаанбаатар	2018.09		Докторант
2	ШУТИС-БАТС	Улаанбаатар	2013.09	2015.09	Бизнесийн удирдлагын магистр
3	ШУТИС-КТМС	Улаанбаатар	1996.09	2000.06	Програм хангамжийн бакалавр
4	Мянгат сургууль ЕБС		1993.09	1996.06	Бүрэн дунд боловсрол
5	Цээл сумын 10 жил		1986.09	1993.06	Дунд боловсрол

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Боловсролын үнэлгээний төв	Захирал	2025 - одоог хүртэл
2	Номадик контент ХХК	Гүйцэтгэх захирал	2018 оноос хойш
3	Монгол контент ХХК	Гүйцэтгэх захирал	2014-2018
4	Монгол контент ХХК, Gogo бизнес ба IT алба	Захирал	2011-2014
5	Монгол контент ХХК, Контент медиа алба	Менежер	2009-2011
6	Монгол контент ХХК, Гар утасны контентийн алба	Менежер	2008-2009
7	Монгол контент ХХК, бизнесийн хэлтэс	Менежер	2005-2008
8	Мобиком корпораци, Шинэ бизнесийн алба	Төслийн ахлагч	2001-2005

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: Энхтөр

Өөрийн нэр: Хүрэлтулга

Төрсөн он: 1995

Төрсөн газар: Ховд хот

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	СЭЗИС- Олон улсын сургууль	Улаанбаатар	2021	2024	Бизнесийн удирдлага MBA, магистр
2	Их засаг их сургууль	Улаанбаатар	2016	2019	Эрх зүйч
3	СЭЗИС	Улаанбаатар	2012	2016	Нягтлан бодогч
4	АССА		2016	2024	ОУ-ын мэргэшсэн нягтлан бодогч
5	CPA		2021	-	Монголын мэргэшсэн нягтлан бодогч

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Монгол Телевиз	Гүйцэтгэх захирал	2024.09 сараас
2	Монгол Телевиз	Үйл ажиллагаа хариуцсан захирал	2022.04- 2024.09
3	Монгол Телевиз	Санхүү эрхэлсэн захирал	2022.04- 2024.09
4	Практикал Даатгал ХХК	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын албаны дарга	2020.05 - 2022.01
5	Хаслизинг	Санхүүгийн шинжээч	2018- 2020
6	Хасбанк	Дотоод аудитор	2016-2018

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Нэргүй**

Өөрийн нэр: **Жавхлан**

Төрсөн он: **1984**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Удирдлагын академи	Улаанбаатар	2013	2014	Төрийн удирдлага
2	СЭЗДС	Улаанбаатар	2008	2011	Бизнесийн удирдлага
3	ШУТИС-ЭХИС	Улаанбаатар	2002	2007	Цахилгааны инженер
4	2-р сургууль	Улаанбаатар	1992	2002	Бүрэн дунд

Гурав. Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Могоул консалтинг сервис ХХК	Гүйцэтгэх захирал	2018 оноос хойш
2	Ай Ти Зон ХХК	Гүйцэтгэх захирал	2014 – 2018
3	Бизнетворк консалтинг ХХК	Захирал	2011 – 2014
4	Синглтон ХХК	Менежер	2009 – 2011
5	Анод банк	Менежер	2008 – 2009
6	БСШУЯам		2005 – 2008

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Содномдорж**
Өөрийн нэр: **Санасэр**
Төрсөн он: **1981**
Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС- Бизнесийн сургууль	Улаанбаатар	2008	2022	Доктор
2	Харвардын Их Сургууль	АНУ	2017	2018	Төрийн удирдлага магистр
3	Калифорнийн Олон Улсын Их Сургууль	Калифорни муж, АНУ	2004	2006	Шинжлэх ухааны магистр
4	МУИС- Эдийн Засгийн Сургууль	Улаанбаатар	1998	2002	Бизнесийн удирдлага
5	Нийслэлийн 50 дугаар дунд сургууль	Улаанбаатар	1988	1998	Бүрэн дунд

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Эм Жи Эл Акуа ХК	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2023 - одоог хүртэл
2	Аргентин, Монголын Бизнесийн Зөвлөл ТББ	Удирдах зөвлөлийн дарга	2022 - одоог хүртэл
3	Монгол Улсын Шадар Сайд-ын	Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зөвлөх	2024 - одоог хүртэл
4	МУИС- Бизнесийн сургууль	Ахлах багш	2007 – одоог хүртэл
5	Волтам ХХК	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022 – 2023
6	МҮОНРТелевиз	Үндэсний зөвлөлийн гишүүн	2015 - 2017
7	Center Chevrolet& Mazda of San Bernardino (АНУ)	Худалдааны зөвлөх	2006-2007

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Амарсайхан**

Өөрийн нэр: **Зоригт**

Төрсөн он: **1982**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	National collage of Ireland	Dublin, Ireland	2012	2014	Business Adminstration
2	МУИС-ийн ЭЗС	Улаанбаатар	1999	2003	Нягтлан бодогч
3	104-р лицей сургууль	Улаанбаатар	1996	1999	Ерөнхий боловсрол
4	31-р дунд сургууль	Улаанбаатар	1989	1996	Ерөнхий боловсрол

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Ла Элпида ХХК	Гүйцэтгэх захирал	2021.06 одоог хүртэл
2	Апичем ХХК	Гүйцэтгэх захирал	2021.01 одоог хүртэл
3	Хос Гоёл ХХК	Гүйцэтгэх захирал	2018.07 одоог хүртэл
4	Таван богд евро автотив ХХК	Гүйцэтгэх захирал	2015 – 2016
5	Бодь даатгал ХХК	Эрсдлийн удирлагын газрын захирал	2015 – 2015

АЙТУУЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН НАМТАР



Нэг. Хувийн мэдээлэл

Эцэг /Эх/-ийн нэр: **Борхүү**

Өөрийн нэр: **Жавхланбаяр**

Төрсөн он: **1979**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

Хоёр. Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Kuban State University	Улаанбаатар	1997	2002	Программ хангамжийн инженер

Гурав: Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Microsoft	Бүс хариуцсан менежер	2014 - одоог хүртэл
2	Microsoft	Дата төвийн техникийн төслийн менежер	2012 - 2014
3	Microsoft	Deployment lead/ Site services technician	2010 - 2012
4	Худалдаа хөгжлийн банк	Мэдээлэл технологийн суппорт менежер	2002 - 2006

АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасныг тус тус удирдлага болгон Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД

АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасныг тус тус удирдлага болгон Айтүүлс ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр

сонгосугай. Үүнд:

Ердийн гишүүд:

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.
- 6.

Хараат бус гишүүд:

- 1.
- 2.
- 3.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД

**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагаа, гишүүдийн цалин,
урамшууллын төсвийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8, Айтүүлс ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардал болон гишүүдийн цалин урамшууллын төсвийг _____ / _____ / төгрөгөөр баталсугай.
2. Төсвийн задаргааг Хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД

АЙТУҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Жилийн зардал, ₮
1	ТУЗ-ийн хурал түүнтэй холбогдох үйл ажиллагааны зардал	1,000,000₮
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	41,300,000₮
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин, урамшуулал	13,500,000₮
4	Бусад зардал	1,000,000₮
НИЙТ ДҮН		56,800,000₮

АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

/Төсөл/

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, Айтүүлс ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 04 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 7.23 дэх заалтыг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.
 - а. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 (хоёр) жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулсанаар бүрэн эрх үргэлжилнэ.
2. Энэ тогтоолын хавсралтаар “Айтүүлс” хувьцаат компанийн дүрмийн өөрчлөлтийг баталсугай.
3. Шинэчилсэн дүрмийг холбогдох журмын дагуу Улсын бүртгэлийн газарт бүртгүүлж, бусад холбогдох байгууллагад хүргүүлж баталгаажуулахыг Гүйцэтгэх захирал /Ч.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.
4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

Г.ХАТАНБОЛД

“АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж байгаа хувьцааны тоо: _____ төрөл: _____ Энгийн _____

Хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансны дугаар: _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Бүртгэсэн ҮЦК-ийн ажилтны овог нэр: _____

Дараах хэлэлцэх асуудлуудад ЕРДИЙН АРГААР санал хураана.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал	Гарын үсэг
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	Тогтоол №1	☐	☐	☐		
2.	ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах	Тогтоол №3	☐	☐	☐		
3.	Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай	Тогтоол №4	☐	☐	☐		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): _____

Огноо: 2025 оны _____-р сарын _____-ны өдөр _____ цаг _____ минут

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: **Тийм / Үгүй** (доогуур зурах)

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____

“АЙТҮҮЛС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж байгаа хувьцааны тоо: _____ төрөл: _____ Энгийн _____

Хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансны дугаар: _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Бүртгэсэн ҮЦК-ийн ажилтны овог нэр: _____

Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал хураана.

№	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгсөн саналын тоо
Ердийн гишүүд		
1		
2		
3		
4		
5		
6		
Хараат бус гишүүд		
1		
2		
3		
4		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): _____

Огноо: 2025 оны _____-р сарын _____-ны өдөр _____ цаг _____ минут

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Таны эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: **Тийм / Үгүй** (доогуур зурах)

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____



САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй тохиолдолд харилцагч брокерын компаниараа дамжуулан хурлын материалтай танилцан саналын хуудсаа өгөх боломжтой.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Ердийн аргаар өгөх санал хураалтад хэлэлцэх асуудал тус бүр дээр нэгээс олон тэмдэглэгээ хийсэн тохиолдолд санал хүчингүйд тооцогдоно.
4. Гарын үсгээ зураагүй санал хүчингүйд тооцогдоно.
5. Итгэмжлэлээр санал өгч буй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэл дээрх өөрийн баталгаат гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
6. Насанд хүрээгүй хувьцаа эзэмшигчийн асран хамгаалагч нь хүүхдийнхээ бус өөрийнхөө гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
7. Кумулятив аргаар ТУЗ-д нэр дэвшигчдэд өгсөн нийт саналын тоо кумулятив саналын тооноос зөрсөн тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.
8. Гарын үсэггүй санал хүчингүйд тооцогдоно.

ДАТА ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИЙН ЧИГ ХАНДЛАГА



КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Өнөөдөр бидэнд үнэ цэнтэй олон мэдээлэл байгаа тул мэдээллийн аюулгүй байдал улам бүр чухал болж байна. Гэхдээ мэдээллийн аюулгүй байдал гэж юуг хэлдэг, яагаад байгууллага бүр өндөр ач холбогдол өгч ажиллах ёстой талаар та мэдэх үү? Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь юун түрүүнд мэдээлэл задрах, гуйвуулах, устгахаас урьдчилан сэргийлэх явдал бөгөөд зөв мэдээллийг зөв хүмүүст, зөв цагт нь өгөх явдал юм. Мэдээлэл буруу гарт орж, буруугаар ашиглагдах ёсгүй. Мэдээллийн аюулгүй байдал нь бизнес болон олон нийтийн үйл ажиллагаа, хувь хүн, албан байгууллагуудад хамаатай. Тиймээс мэдээллийн аюулгүй байдал нь нийгмийг бүхэлд нь хамардаг.



“Мэдээллийн аюулгүй байдал нь таны хөрөнгийг хамгаалдаг”

➤ **Кибер аюулгүй байдал**

Дэлхий урьд өмнөхөөсөө илүү технологид тулгуурлаж байгаа ба аж ахуйн нэгжүүд компьютер дээр их хэмжээний өгөгдлийг хадгалж, сүлжээгээр бусад компьютерт дамжуулан, дижиталчлал үргэлжлэх тусам цаашид илүү нэмэгдэх болно. Дижитал хэлбэрт шилжиж буй шилжилт нь эерэг зүйл хэдий ч нөгөө талаараа илүү эмзэг болж байна гэсэн үг. Иймээс кибер аюулгүй байдал хамгийн чухал.



“Кибер аюулгүй байдал нь сүлжээ, төхөөрөмж, программ болон өгөгдлийг халдлага, зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалах тухай байдаг бөгөөд өгөгдөлд зөвшөөрөлгүй цахим хандалтаас хамгаалах явдал юм.”

Илүү цахимжсан ертөнц нь халдагчдад цохилт өгөх боломж улам бүр нэмэгдэж байна гэсэн үг. Таны сүлжээнд холбогдсон бүтээгдэхүүнүүд хэдий чинээ олон байна, халдагчид төдий чинээ олон арга зам бий.

➤ **Цахим халдлагын нийтлэг төрлүүдийг авч үзвэл:**

➤ **Ransomware**

Ransomware гэдэг нь таны компьютерт хадгалагдаж буй нэн чухал хэрэгцээтэй файлуудыг тусгай аргаар шифрлэж дахин ашиглах боломжгүй төрөлд хувирган форматыг өөрчилдөг хортой код юм. Ransomware нь таны файлыг encrypt хийсний дараа танаас төлбөр нэхэх ба таныг төлбөрөө төлсний дараа таны файлыг decrypt хийдэг.

➤ **Фишинг халдлага**

Фишинг (Phishing) гэдэг нь хамгийн энгийнээр тайлбарлавал хүний хувийн мэдээллийг хулгайлах гэсэн кибер гэмт хэрэг юм. Халдлага үйлдэгч буюу фишер нь ялангуяа хэрэглэгчийн хувийн мэдээллийг (нэвтрэх нэр, нууц үг, пин код гэх мэт) хулгайлах зорилготой байдаг. Тэд мэдээллийг хулгайлахын тулд итгэмжлэгдсэн олон нийтийн сүлжээг (цахим шуудан, утас, мессенжер чат, мессеж гэх мэт) дуурайн ашиглаж түүгээр дамжуулан хэрэглэгчийн мэдээллийг авахыг оролддог. Фишерүүд нь хэрэглэгчийн мэдээллийг хуурч авсны дараа мэдээллийг буруугаар ашиглан таныг санхүүгийн алдагдалд хүргэх, сэтгэл зүйгээр хохироход ч хүргэж болзошгүй юм.

➤ **Нийгмийн инженерчлэл**

Нийгмийн инженерчлэл (Social Engineering) гэдэг нь хүмүүсийг тодорхой үйлдэл хийх, эсвэл нууц мэдээлэл задруулахад нь сэтгэлзүйн аргаар итгүүлж удирдах үйл явцыг хэлнэ. Энэ нь техникийн хакерын аргыг ашиглахын оронд хүний сэтгэлзүйг ашигладаг. Нийгмийн инженерүүд итгэлцэл бий болгох, яаралтай байдал үүсгэх эсвэл хууль ёсны байгууллагыг дуурайх зэрэг аргачлалуудыг ашиглан хүмүүсийг нууц үг, санхүүгийн мэдээлэл, эсвэл системийн нэвтрэх эрх зэрэг эмзэг мэдээллийг задруулахад хуурч мэхэлдэг.



“Кибер халдлага нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй юм”

Кибер халдлагад өртөх нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй. Үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болохоос эхлээд үйл ажиллагаа бүрэн зогсох ч эрсдэлийг дагуулдаг.


> **Монгол улсад кибер халдлага**

Сүүлийн жилүүдэд Монгол улсад зорилтот халдлага, зөрчил, кибер гэмт хэргийн тоо улам бүр өссөөр байгаа бөгөөд манай улсад 7 хоногт дунджаар 8000 гаруй IP хаягт 70,000-80,000 кибер халдлага, зөрчил илэрч бүртгэгддэг бөгөөд үүний 71% нь хортой код, 20% нь системд хайлт хийх, 4.4% нь эмзэг байдлын цоорхой ашиглах, 2.1% нь нууц үг тайлах оролдлого хийх төрлийн халдлага зөрчил байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээгээр сүүлийн хагас жилийн байдлаар нийт 1246 дуудлага мэдээлэл хүлээн авснаас интернэт банкны халдлага 48, цахим залилан 853, худал мэдээлэл тараах 29, цахим мөрийтэй тоглоом 59, Фэйсбүүк халдлага 193, андуурсан гүйлгээ 51 байна. Нийт хохирлын хэмжээ 4,591,560,643 төгрөг байна /Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам/

Ингээд харахад Дижитал шилжилт хийгдэхийн хажуугаар Кибер аюулгүй байдлаа хамгаалах нь хамгийн чухал асуудал болоод байгаа билээ.

Айтүүлс ХК-ийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т. Энхмаа



ЯАГААД ТАНД PASSWORD MANAGER ХЭРЭГТЭЙ ВЭ?

Өнөө цаг үед кибер аюулгүй байдлын халдлага нь дэлхий даяар бизнес эрхлэгчдэд томоохон эрсдэл мөн заналхийлэл болж байна. Цар тахлын дараах Цахим орчны үйлчилгээ нь эрүүл мэндийн үзлэгээс эхлээд хүнсний дэлгүүрээс бараа захиалах, хувцас захиалах, Театрт жүжиг үзэхээс үүдэн цахим орчноор хувийн мэдээллээ ашиглан захиалга хийх бүрд биечлэн хийх үйл ажиллагааг орлож кибер эрсдэлд оруулж байна.

Корона вирусийн цар тахлын дараах энэ үед зайнаас ажилладаг ажилчдын тоо нэмэгдэж, энэ нь эргээд аюулгүй байдлын зарим асуудлыг үүсгэж байгаа билээ. Учир нь цар тахал нь бидний өдөр тутмын амьдралыг эрс өөрчилсөн бол үүний үр дүнд кибер аюулгүй байдлын тогтворгүй байдал нь хувь хүн болон бизнес эрхлэгчид кибер халдлагын эсрэг хэт сонор сэрэмжтэй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Магадгүй өнөөдөр гэрээсээ эсвэл кофе шоп, түгжрэл дунд машинаасаа буюу алсын зайнаас ажиллах нь кибер гэмт хэрэгтнүүдэд сүлжээ, системийг хакердах асар их боломжийг бий болгож кибер гэмт хэрэгтнүүдийн номер нэг бай болоод байна. Өнгөрсөн онд McKinsey's American Opportunity Survey-ийн мэдээлснээр Америкчуудын 58% нь долоо хоногт ядаж нэг өдөр гэрээсээ ажиллах боломжтой болсон. Хэдийгээр уян хатан ажлын хуваарийг цар тахлын эсрэг түр зуурын хариу арга хэмжээ гэж үздэг байсан ч энэ нь одоо байнгын шинж чанартай болоод байгаа юм. Мөн Интернэт гэмт хэргийн гомдлын төвийн мэдээлснээр цар тахал эхэлснээс хойш одоог хүртэл бүртгэгдсэн цахим гэмт хэргийн тоо 300 хувиар өссөн. Тиймээс кибер гэмт хэргээс сэргийлэх хамгийн эхний алхмыг танд зөвлөж байна.

Энэ нь хувь хүн таны болон байгууллага хамт олонд тань зориулсан хэрэг болох нууц үгийн удирдлага (Password Manager) программ юм.

> **Тэгэхээр, Нууц үгийн удирдлага гэж юу вэ?**

Нууц үгийн удирдлага нь таны хадгалахыг хүссэн бүх нууц үгээ үүсгэж, бүгдийг нэг дор хадгалж болох программ юм. Энэхүү программ нь нууц үгийг найдвартай хадгалдаг бөгөөд таны нэвтрэх шаардлагатай вэб сайт (Facebook, Instagram, X, Gmail, Business Email) болон хэрэгцээт апп-ууд дээр аюулгүй байлгах хүчтэй, нууц үгнүүдийг үүсгэх боломжийг олгоно. Энэ нь таныг онлайн орчинд аюулгүй байлгах хамгийн эхний алхам юм.

> **Нууц үгийн удирдлага нь танд хамгийн энгийн гурван аргаар тусалж чадна үүнд:**

1. Нууц үгийн аюулгүй байдлыг хангахын тулд

Нууц үгийн удирдлага нь танд шифрлэгдсэн нууц үгээ хадгалахад тусалж зөвхөн таны нууц үгнүүдийг багтаасан database үүсгэнэ ингэснээр та өөрийн бүртгэлийн мэдээлэлдээ заавал төрсөн он сар, нэр, утасны дугаар гэх мэт зүйлүүдийг бичих шаардлагагүй болж үүгээр зогсохгүй өөрийн бусад онлайн бүртгэл болох Social Account, Bank Account зэргийн нууц үгээ хэзээ алдах бол гэсэн эрсдэлээс өөрийгөө хамгаалж болохоос гадна танаас өөр хэн ч хандаж чадахгүйгээр нууц үгээ хамгаалж чадна.

2. Илүү хүчтэй нууц үг үүсгэхийн тулд

Нууц үгийн удирдлага нь хүчтэй буюу тусгай тэмдэгт, тоо, үсэг зэргийг багтаасан урт хэмжээний нууц үг үүсгэж өгөх ба өөрийн болон таны бизнесийн кибер аюулгүй байдлыг бэхжүүлж, нууц үгийг хакердах, хулгайлах эрсдэлийг бууруулдаг. Үүний үр дүнд та бүртгэл бүртээ нэгэн ижил давтагдсан нууц үг ашиглах шаардлагагүй болох ба гадны халдагч таны нэг нууц үгээр бусад бүртгэлд нэгэн зэрэг нэвтрэх чадахгүй байх боломжийг үүсгэх болно. Нууц үг бүрийг стандарт нууц үгийн бодлогын дагуу үүсгэнэ.

3. Аюулгүй, хялбар хурдан нэвтрэхийн тулд

Та нэвтрэх бүртээ бүх нууц үгээ санах шаардлагагүй. Нууц үгийн удирдлага нь нууц үгийн аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр таны үүсгэсэн хүчтэй нууц үгийг автоматаар бөглөх хялбар функцээр хурдан нэвтрэхэд танд тусална.

Тиймээс танд болон таны байгууллагын хамт олонд Password Manager-ийг ашиглаж хэвшихийг зөвлөж байна. Яагаад гэвэл хувь хүмүүс болон томоохон аж ахуйн нэгжүүд мэдээллээ алдах буюу эрсдэлд учрах магадлал өндөр байдаг. Учир нь кибер гэмт хэрэгтнүүд чухал, үнэ цэнтэй, хувийн, томоохон мэдээллийг олж авахыг эрмэлздэг бол хохирогчдыг ялгадаггүй. Хакерууд нэг дор олон мянган хүмүүсийн мэдээллийг олж авах боломжтой тул компаниудыг онилсон үед учирсан хохирол нь ихэвчлэн өндөр байдаг.

> **Тиймээс танд дараах Password Manager-үүдийг санал болгож байна.**

Desktop software:

1. Bitwarden
2. KeePassXC
3. Keeper
4. NordPass

Browser Extensions:


1. Lastpass
2. Dashlane
3. 1 Password

Айтүүлс ХК-н системийн админ **Ч. Билгүүнтөгс**

ТЕХНИКИЙН ДЭМЖЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Таны дуртай веб сайт, аппликейшн болон онлайн үйлчилгээг ямар ч саадгүй ажиллуулдаг талаар та бодож байсан уу? Хөшигний ард бүх зүйлийг хэвийн байлгахын тулд уйгагүй ажиллаж байгаа хэсэг бүлэг баатрууд байдаг. Тэд бол системийн администраторууд юм. Энэхүү блог нийтлэлд бид мониторинг болон нөөцлөх үйлчилгээг онцолж техникийн дэмжлэг үйлчилгээний ач холбогдол болон дижитал эрин зуунд яагаад чухал болохыг харуулах болно.

Мониторинг болон нөөцлөх үйлчилгээний онцлогийг судлахын өмнө эхлээд системийн администраторуудын үүргийг ойлгоцгооё. Технологийн мэдлэгтэй эдгээр хүмүүс манай дижитал ертөнцийг тэжээдэг техник хангамж, программ хангамж, сүлжээг удирдах, засварлах, оновчтой болгох үүрэгтэй. Системийн админууд нь серверүүдийг тохируулахаас эхлээд техникийн асуудлыг шийдвэрлэх хүртэл аливаа байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтцийн тулгуур хэсэг болдог.



1. Мониторинг үйлчилгээний ач холбогдол

Та алдартай цахим худалдааны веб сайт ажиллуулж байна гэж төсөөлөөд үз дээ, гэнэт дэлгүүр хэсэх ачаалал ихтэй үед гацаж байна. Гамшиг, тийм үү? Эндээс л мониторинг үйлчилгээ орж ирдэг. Системийн администраторууд серверийн ажиллах хугацаа, сүлжээний ачаалал, программын хариу үйлдэл зэрэг системийн гүйцэтгэлийн янз бүрийн талыг байнга хянаж байхын тулд нарийн төвөгтэй хяналтын хэрэгслийг ашигладаг. Мониторинг үйлчилгээ нь гарах магадлалтай асуудлуудыг урьдчилан илрүүлж, шийдвэрлэснээр өндөр өртөгтэй зогсолтоос сэргийлж, үйл ажиллагааг тасалдалгүй үргэлжлүүлэх боломжийг олгодог.

Жишээ: Та тоглоом сонирхогч гэж бодъё, тоглолтоо шууд үзэгчдэд дамжуулж байна. Үр дүнтэй Мониторингийг хийснээр системийн админууд нь CPU-ийн ашиглалтын огцом өсөлт эсвэл сүлжээний түгжрэл байгаа эсэхийг хурдан тодорхойлж, гүйцэтгэлийг оновчтой болгож, таны дамжуулалтыг хэвийн үргэлжлүүлэхийн тулд яаралтай арга хэмжээ авснаар таны шууд дамжуулалтыг үзэгчдэд саадгүй хүргэх юм.

2. Нөөцлөлтийн ач тус

Дата буюу өгөгдөл бол аливаа байгууллагын амин сүнс бөгөөд түүнийг алдах нь сүйрлийг илтгэнэ. Системийн администраторууд чухал өгөгдөл, программууд болон тохиргоог тогтмол бөгөөд найдвартай хуулбарлах найдвартай нөөцлөлтийн шийдлүүдийг хэрэгжүүлдэг. Техник хангамжийн доголдол, кибер халдлага эсвэл санамсаргүйгээр устгасан тохиолдолд эдгээр нөөцлөлтүүд нь аюулгүй байдлын сүлжээ болж, хурдан сэргээх, сул зогсолтыг багасгах боломжийг олгодог.

Жишээ: Үйлчлүүлэгчийн чухал файлуудыг санамсаргүйгээр устгасан жижиг бизнес эрхлэгчийг төсөөл. Автомат нөөцлөлтийн үйлчилгээний ачаар системийн админ нь саяхны нөөцлөлтөөс алдагдсан өгөгдлийг хурдан сэргээж, өдрийг хэмнэж, бизнесийн найдвартай байдлын нэр хүндийг хадгалах боломжтой. Мөн кибер халдлагад өртөж мэдээллээ ransomware-д алдсан тохиолдолд ч нөөцлөлтөөс мэдээллээ сэргээнэ шүү дээ. Та хакерт мөнгө төлмөөргүй байгаа нь лавтай.

> Дүгнэлт

Дүгнэж хэлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь бидний амьдарч буй дижитал ертөнцийг хүчирхэгжүүлэхэд ямар чухал үүрэг гүйцэтгэдгийг харлаа. Тиймээс, та дуртай веб сайтаа үзэх эсвэл мобайл апп ашиглахдаа эдгээр технологийн баатруудын хөшигний ард тасралтгүй найдвартай ажиллаж байдгийг ойлгосон байх.

Та дижитал дэд бүтцийнхээ тасалдалгүй найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахад бэлэн үү? Тэгвэл та Айтүүлс ХК-н Монголдоо анхлан гаргаж буй Техникийн дэмжлэгийн үйлчилгээний хэрэглэгч болж технологио шинэ өндөрлөгт авчраарай!

Та Айтүүлс ХК-н 7575-5585 лавлах дугаар болон онлайн чатуудаар холбогдон Техникийн дэмжлэгийн үйлчилгээтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

Айтүүлс ХК-н Техникийн дэмжлэгийн хэлтсийн менежер **Б. Болор**

ISO27001 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Мэдээлэл, өгөгдөл нь аливаа байгууллагын хамгийн үнэ цэнтэй хөрөнгө болсон дижитал эрин зуунд түүний аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал гэдэгтэй хүн бүхэн санал нийлэх биз ээ. Тэгвэл яаж ? Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, үйл ажиллагааг сайжруулахад зориулагдсан олон стандарт байдаг ч эдгээрээс бизнесийн ямар салбарт үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран хамгийн өгөөжтэй, зардал багатай, үр нөлөөтэйгөөр нэвтрүүлэх боломжтой стандарт бол ISM ISO27001 стандарт юм. Уг стандартыг нэвтрүүлснээр танай байгууллага кибер аюул заналхийллээс хамгаалах хамгаалалтыг бэхжүүлээд зогсохгүй бусад олон төрлийн давуу талыг өөрийн бизнест олох боломжтой.

Юуны өмнө ISO27001 стандартын хэрэгжилт нь байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын байр суурийг баттай бэхжүүлэхээс гадна мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийг үнэлснээр эрсдэлийг үр дүнтэй бууруулах, хяналт тавих, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх боломжийг олгодог. Энэхүү аргачлал нь мэдээллийн аюулгүй байдлын аливаа зөрчил, мэдээлэл алдагдах болон бусад төрлийн кибер халдлагад өртөх магадлалыг бууруулж, байгууллагын нууц мэдээллийг хамгаалж, эдгээрийг алдагдуулснаас үүсэх байгууллагын бизнесийн нэр хүнд алдагдах, санхүүгийн хохирол амсах зэргээс хамгаалах хамгаалалт болдог.

➤ **Ижил төрлийн бусад стандартыг нэвтрүүлэх суурь**

Аливаа бизнесийн салбарын хэрэгжүүлэх шаардлагатай дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөх нь бизнесээ амжилттай авч явах нэгэн чухал хэсэг. ISO27001 стандарт нь олон улсын GDPR, HIPAA, PCIDSS зэрэг бусад мэдээлэл хамгаалах чиглэлийн стандартуудын шаардлагад нийцсэн тогтолцоог бүрдүүлдэг. Ингэснээр танай байгууллага өөрийн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан бусад төрлийн мэдээлэл хамгаалах стандартыг нэвтрүүлэхэд дөхөм, түлхэц болж өгнө гэсэн үг юм.

➤ **Бизнесийн өрсөлдөөний давуу тал**

ISO27001 стандарт хэрэгжүүлсэн компани нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас өрсөлдөх чадвараар дээгүүр гэдгийг илэрхийлэх илэрхийлэл болж өгдөг. Хэрэглэгч, харилцагч байгууллага, салбарын зохицуулалтын байгууллагууд гээд байгууллагын оролцогч талууд аюулгүй байдал, нууцлалыг эрхэмлэдэг, үнэлдэг өнөөгийн зах зээлд уг стандарт нь маркетингийн хүчирхэг хэрэгсэл болохын сацуу эдгээр сонирхогч талуудын таны бизнест итгэх итгэлийг нэмэгдүүлэх, шинэ боломж, бизнесийн өсөлтийг дэмжих хэрэгсэл болдог.

➤ **Үйл ажиллагааны тогтмол сайжруулалт**

Аливаа стандартыг нэвтрүүлэх нь байгууллагад дотоод процесс сайжрах, дүрэм журмын хэрэгжилт, тэдгээр дээр тавигдах хяналтыг бодитойгоор сайжруулах эерэг сайн нөлөөг үзүүлдэг. ISO27001 стандартыг хэрэгжүүлэх нь мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог удирдахтай холбоотой аливаа үйл явц, холбогдох дотоод дүрэм журмыг оновчтой болгож өгдөг. Эдгээр нь байгууллагын ажилчдыг эмзэг мэдээлэлтэй үр нөлөөтэй, аюулгүйгээр ажиллах, системийн эмзэг байдлыг бүхэлд нь тогтмол хянаж, аливаа гарсан зөрчлийг цаг алдалгүй мэдээлэх, арилгах аргачлалыг тусгадаг тул үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд тусалдаг.

➤ **Эрсдэлийн удирдлага**

ISO27001 стандартын хэрэгжилтийн гол цөм нь эрсдэлийн үр дүнтэй удирдлага. Аливаа гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийг үнэлж, авах арга хэмжээний төлөвлөлтийг хэрэгжүүлснээр байгууллагын мэдээллийн хөрөнгөд учирч болзошгүй аюул заналхийллийг оновчтой тодорхойлж, үнэлж бууруулах зарчмыг баримталдаг. Энэ арга нь аюулгүй байдлын эсрэг тохиолдох аливаа нөхцөл байдлын нөлөөллийг багасгахаас гадна хариу арга хэмжээний оновчтой шийдвэр гаргах, нөөцийг үр дүнтэй хуваарилах боломжийг олгож, бизнесийн урт хугацааны тогтвортой байдлыг бүрдүүлдэг.

➤ **Хэрэглэгчийн итгэл**

Цахим халдлага, цахим гэмт хэрэг өдөр бүр, цаг минут тутамд хийгддэг болсон өнөө үед харилцагч, хэрэглэгчийнхээ мэдээллийг найдвартай, аюулгүй хамгаалах гэдэг нь урьд өмнөхөөсөө илүүтэй чухал, үнэ цэнтэй зүйлсийг нэг болсон. ISO27001 стандартыг нэвтрүүлэх нь хэрэглэгчдэд тэдний үнэ цэнтэй мэдээллийг тухайн байгууллага хэрхэн чухалчилж, нэн тэргүүнд авч үзэж байгааг илэрхийлэх илэрхийлэл болдог. Энэ нь үйлчлүүлэгчдийн тогтвортой хамтын ажиллагааг бэхжүүлэхээс гадна бизнесийн харилцаанд аюулгүй байдал, мэдээллийн үнэ цэнийг мэддэг шинэ хэрэглэгчдийг татаж байдаг.

Айтүүлс ХК – нь хэрэглэгчийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлалтай мэдээллийг хадгалах, хамгаалах хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор олон улсын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO27001:2013 стандартыг 2023 оноос үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж ажиллаж байна.

Айтүүлс ХК-н Техникийн үйл ажиллагааны хэлтсийн менежер **Ч. Гансүлд**

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ДАТА ТӨВД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хиймэл оюун ухаан буюу AI аль хэдийнээ бидний амьдралын нэгэн хэсэг болжээ. Open AI-н гаргасан ChatGPT гэхэд л нэгхэн шөнийн дотор хэдэн зуун сая хэрэглэгчтэй болсон нь AI моделиуд хаалттай ажилладаг байсан цаг нэгэнт ард хоцорсныг илтгэж байна.

Сүүлийн үед бүхий л салбарт үйл явцыг хөнгөвчлөх, үр дүнг сайжруулах AI функцийг нэвтрүүлэхээр эрэлхийлж байгаа. Дата төв нь энэхүү дижитал шилжилтэд AI програмуудын ажиллах боломжийг хангах онцгой үүрэгтэй ба дагаад түүнээсээ ашиг тус хамгийн ихээр хүртэх салбаруудын нэг юм. Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх болон хэрэглэгчдэд хүргэхэд асар их хэмжээний тооцоолох хүчин чадал болон өгөгдөл хадгалах шаардлагатай.

Дата төвүүд технологид суурилсан ертөнцийн гол ноён нуруу болж уг шаардлагуудыг хангах чухал үүрэгтэй. Гэвч энэхүү хурдацтай өсөн нэмэгдэж буй эрэлт нь дата төвүүдийг AI-д суурилсан илүү үр дүнтэй, аюулгүй, үр ашиг өндөр шинэ технологи бүхий систем ашиглахыг шаардаж байгаа.

Тэгвэл энэхүү блогороо бид AI дата төвийн салбарын ирээдүйг хэрхэн тодорхойлж байгаа талаар хүргэх юм. Ялангуяа AI ба автоматжуулалт хэрхэн дата төвүүдийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг нэмэгдүүлэн нөөцийн менежментийг сайжруулж буй талаар өгүүлнэ.

> **Дата төвийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө**

AI болон машин сургалтын алгоритмууд нь өгөгдөлд суурилан зүй тогтлыг илрүүлэхдээ маш сайн. Ингэснээр тэд суралцсан зүйлсээ ашиглан өдөр тутмын олон үйл ажиллагааг автоматжуулж, оновчтой болгодог.

Сүүлийн жилүүдэд дата төвийн бизнес эрхлэгчид өдөр тутмын үйл ажиллагаагаа хялбаршуулах зорилгоор AI-г ашиглах болсон байна. Саяхан хийгдсэн судалгаагаар дата төвийн үйл ажиллагаа эрхлэгчдийн 57 хувь үйл ажиллагааны шийдвэр гаргалтад AI ашиглана гэж хариулсан нь өмнөх оныхоос 20 хувиар өсжээ. Тодруулбал, AI-г ашиглан дата төвийн хөргөлтийн системийн бодит сайжруулалтыг хийх боломжтой. Маш их хэмжээний тооцоолол хийхэд шаардагдаж буй хүчин чадал нь тэр хэмжээний халалтыг үүсгэдэг. Харин AI-г тоног төхөөрөмжийн хөргөлтийн системд ашигласнаар зардал хэмнэх болон эрчим хүчний үр ашгийг сайжруулах давуу талыг олгодог. Жишээ нь: Google AI-д суурилсан системийг нэвтрүүлснээр хөргөлтийн зардлыг 40%-иар бууруулсан байна.

AI нь мөн мэдээллийн технологийн дэд бүтцийн үр ашиггүй байдлыг бууруулах чадамжтай. Урьдчилсан тооцооллын тусламжтайгаар эрчим хүчний хуваарилалт болон gas буюу серверийн тавиуруудын байршил, дүүргэлтийг хамгийн зөвөөр зохион байгуулна. Үр дүнд нь үйл ажиллагааны зардал бууран эрчим хүчний хэрэглээний үр ашиг нэмэгдээд зогсохгүй өгөгдөлд суурилсан, илүү мэдээлэлтэй шийдвэр гаргалтыг хийх боломжийг үйл ажиллагаа эрхлэгчдэд олгож байгаа юм.

> **Дата төвийн нөөцийн менежментийг оновчтой болгох**

Орчин үед дата төвүүд асар их ачаалалтай ажиллаж байна. ChatGPT-н жишээн дээр тулгуурлан AI-г сайжруулах болон хэрэглээнд нэвтрүүлэхэд 2028 он гэхэд 76 тэрбум ам.долларыг зарцуулна хэмээн тооцоолжээ. Уг дүн нь дэлхийн хамгийн том үүлэн (public cloud) үйлчилгээг нийлүүлэгч Amazon Web Services-н жилийн зардлаас 2 дахин их дүн юм.

> **Ажлын ачааллын удирдлагыг сайжруулах**

Дата төвүүдэд ажлын ачаалал болон хуваарилалтыг сайжруулахын тулд AI-г аль хэдийнээ ашиглаад эхэлжээ. Энэхүү шийдэл нь техник хангамж, сүлжээг илүү үр ашигтай ашиглах, тасалдал үүсэхээс зайлсхийх, үйлчилгээг тогтмол өндөр түвшинд хүргэхэд тусална.

> **Бизнесийн тасралтгүй байдлыг хангах**

Бид AI-н урьдчилсан тооцооллын тусламжтайгаар бизнесийнхээ тасралтгүй байдлыг хангах бүрэн боломжтой. AI алгоритм нь асуудлыг тохиохоос өмнө илрүүлж, тасалдлын хугацааг болон тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх зардлыг эрс багасгана. McKinsey-н тооцоолсноор компаниуд AI-г ашиглан засвар үйлчилгээ болон тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийх зардлыг 25% хүртэл бууруулах боломжтой гэж үзжээ.

> **Хэрэглэгчийн туршлагыг сайжруулах**

Ажлын ачааллыг хуваарилалтыг сайжруулна гэдэг нь дагаад үйлчилгээний чанар сайжирна гэсэн үг юм. AI-ы тооцоолол нь нөөцийг хамгийн зөвөөр хуваарилан, зардлыг бууруулан хэрэглэгчдэд хамгийн сайн туршлагыг бий болгоно. Хамгийн гол нь AI нь дата төвийн дэд бүтцийг боломжит дээд хүчин чадлаар нь ажиллуулж зөвхөн эцсийн хэрэглэгчдээр зогсохгүй үйлчилгээ үзүүлэгчдийн үр ашгийг нэмэгдүүлэх юм.

> **AI нь дата төвийн аюулгүй байдлыг сайжруулдаг**

AI-г мөн дата төвийн аюулгүй байдлыг сайжруулахад ашиглах боломжтой юм. Кибер аюул байнга хувьсан өөрчлөгдөж байгаа тул уламжлалт аюулгүй байдлын системүүд шинэ аюул заналхийллийг сурах эсвэл хамгаалалтын үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд удаашралтай байдаг. AI ашиглах нь уг эрсдэлийг бууруулан дата төвүүдэд санаачилгыг гартаа авахад тусална.

Тодруулбал, AI-г ашигласнаар дараах байдлаар аюулгүй байдлыг сайжруулахад боломж үүснэ:

- < Сэжигтэй үйлдлийг илрүүлэх: AI-д суурилсан системээр сүлжээний урсгал, хандалтын бүртгэл, системийн үйлдлийг хянаснаар сэжигтэй үйлдлийг тодорхойлох тэдгээрийг асуудал үүсгэж эхлэхээс өмнө алдааг олж илрүүлэх боломжтой. Үүний тусламжтайгаар аюулгүй байдлыг хариуцсан багууд хохирол учруулахаас өмнө болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээг авдаг байна.
- < Урьдчилан сэргийлэх арга хэмжээг түлхүү ашиглах: Уламжлалт аюулгүй байдлын арга хэмжээ нь асуудлаас сэргийлэх гэхээсээ илүү тулгарсны дараа засах үйлдлийг хийх төлөвтэй байдаг. AI шинжилгээ нь дата төвүүдэд болзошгүй аюул, эмзэг байдлыг урьдчилан таамаглах боломжийг олгодог бөгөөд халдагчид давуу талыг гартаа авахаас өмнө хамгаалалтын цоорхойг арилгадаг байна.
- < Өгөгдлийг хамгаалах: AI алгоритм, техникийг ашигласнаар дата төвүүд өгөгдөл боловсруулах, хадгалах, аюулгүй байдлыг сайжруулах боломжтой.

> **Дата төвийн ирээдүй**

Ирээдүйд дата төвүүд үр ашигтай, үр нөлөөтэй үйлчилгээг үзүүлэхийн тулд асар хурдацтай өөрчлөгдөж буй технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах нь зайлшгүй шаардлага болоод байна. Жишээлбэл дэвшилтэт AI, квант тооцоолол болон бусад шинэ технологиуд нь дата төвийн ирээдүйг ямар байх шаардлагатайг тодорхойлж байна. Эдгээр хамгийн сүүлийн үеийн технологиуд нь бидэнд илүү үр ашигтай, ахисан түвшний боломжуудыг санал болгох юм. Өмнө дурдсанчлан маш их хэмжээний тооцоолол хийхийн тулд ажиллаж байгаа хүчтэй тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтлээс хамгаалахаар шингэн хөргөлтийн системийг ашигладаг ба үүнтэй холбоотойгоор дата төвийн цахилгаан зарцуулалт 2030 он гэхэд 12%-иар өсөх төлөвтэй байна. AI-г дата төвд ашигласнаар үйлчилгээ үзүүлэгчдэд өөрчлөгдөж буй хэрэгцээнд нийцэн хөгжих, ирээдүйд хүлээгдэж буй өргөн цар хүрээ бүхий дижитал орчны гол тулгуур болох боломжийг олгох юм.

> **Дата төвийн AI: Хураангуй**

Эцэст нь... AI нь үндсэндээ дата төвийн салбарыг асар хурдацтайгаар шинэчлэж байна.

- < AI урьдчилан тооцоолол нь байнгын үйл ажиллагааг автоматжуулах, нөөцийн удирдлагыг оновчтой болгохын зэрэгцээ шинээр гарч ирж буй аюулаас хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтыг сайжруулахад тусалдаг.
- < AI үүрэг нь нөөцийг удирдахад ч хамаатай. Засвар үйлчилгээ, ажлын ачааллын хуваарилалтын зардлыг ихээхэн хэмнэж, үйлчилгээний чанарыг сайжруулж, тасалдлаас хамгаалдаг.
- < Дата төвүүд нь AI болон шинээр гарч ирж буй технологиор ажиллах болно. Цаашид хөгжиж буй технологиуд нь дата төв дахь AI хэрэглээг улам бүр нэмэгдүүлнэ. AI-г шинэ технологитой хослуулснаар дата төвүүд ирээдүйн бизнесүүдэд шаардлагатай өндөр гүйцэтгэлтэй үүлэн үйлчилгээг үзүүлж чадна.

Айтүүлс ХК-н Маркетинг, борлуулалтын хэлтсийн менежер Д. Жигжид



www.itools.mn



75755585



info@itools.mn

